

**МОНГОЛ УЛСЫН
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ**



**СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ,
ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

Хянасан:

Д.Чинзориг

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, доктор (Ph.D), хурандаа

Судалгааны багийн ахлагч:

Э.Батбаяр

Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, хурандаа

Судалгааны багийн гишүүд:

Б.Нямгомбо

ШШГЕГ-ын Захиргааны удирдлагын газрын дарга, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, хурандаа

Я.Батгэрэл

Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, хууль сахиулахуйн доктор (Ph.D), хурандаа

Д.Буяннэмэх

Аюулгүй байдлын тэнхимийн профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд хурандаа

П.Баярбаатар

Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн тэнхимийн дэд профессор, хууль сахиулахуйн доктор (Ph.D), дэд хурандаа

М.Даваабат

Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, хууль сахиулахуйн доктор (Ph.D), хошууч

Б.Сайнбаяр

Мөн тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч

Б.Уянга

Мөн тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, ахлах дэслэгч

Ч.Цэнд-Аюуш

Е-сургалтын институтийн багш, хууль зүйн магистр, ахмад

Г.Амгаланбаатар

Докторант, хурандаа

Э.Тамир

Докторант, хурандаа

О.Жамъянпүрэв

Магистрант, ахлах дэслэгч

**СЭЖИГТЭН ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ
ГҮЙЦЭТГЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТАНДАН
СУДЛАХ СУДАЛГАА**

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2-3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ.....	6
1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох	8
1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох	19
1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл	20
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	21
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	23
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	28
4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	28
4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	34
4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө.....	38
4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	43
4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх	46
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ	50
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	53
6.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улс.....	53
6.2. Оросын холбооны Улс	54
6.3. Бүгд Найрамдах Казахстан Улс.....	55
6.4. Япон Улс	56
6.5. Бүгд Найрамдах Турк Улс	56
6.6. Бүгд Найрамдах Франц Улс	57
ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	59
НОМ ЗҮЙ	62

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУҮндХ	Монгол Улсын Үндсэн хууль
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
СЯБЦХШБТХ	Сэжигтэн яллагдагчийн баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ДХИС	Дотоод хэргийн их сургууль
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
ШШГАС	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны сургууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хордогсдын тоон үзүүлэлт	13
Хүснэгт 2. Хууль ёсны эрх ашиг зөрчигдөж буй этгээдүүд.....	19
Хүснэгт 3. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал.....	23
Хүснэгт 4. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	28
Хүснэгт 5. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	34
Хүснэгт 6. Нийгэмд үзүүлэх үр нөлөө	38
Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө.....	43
Хүснэгт 8. Зохицуулалтын хувилбарыг харьцуулсан дүгнэлт	50

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоолыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх эрх зүйн зохицуулалттай.

Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт нь Улсын Их Хурлаас 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлан мөрдүүлж эхэлсэн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” юм. Уг хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зарим өвөрмөц харилцааг зохицуулдаг боловч нийгмийн харилцааны хөгжил, эрүүгийн процессын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл, бэрхшээл үүсэх болсон байна. Өөрөөр хэлбэл, Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль нь 5 бүлэг 45 зүйлтэйгээр батлагдан, дагаж мөрдөж (УИХ, 1999) эхэлсэн 27 жилийн хугацаанд 2000, 2002, 2003, 2013, 2017 онд гэхэд 4 удаа, 2020, 2024 онуудад нийт 10 удаагийн нэмэлт өөрчлөлтөөр давхардсан тоогоор 47 зүйл заалтыг өөрчлөн найруулсан ч хувьсан шинэчлэгдэж буй нийгмийн харилцааг зохицуулж чадахгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна. Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.11-2-г зааснаар хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, жирэмсэн яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болох талаар хуульчилсан хэдий боловч СЯБЦХШБТХ-д цагдан хоригдох үеийн орчин нөхцөл, эрх зүйн байдлын талаар нярай хүүхдийн талаар нарийвчлан зохицуулсан зохицуулалт байхгүй, хүний эрхийг хангах чухал асуудал орхигдсон зэргийг дурдаж болно.

Энэхүү ганцхан жишээнээс үзэхэд “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх нөхцөл, журам, түүнтэй холбоотой харилцааг зохицуулах зорилготой эрх зүйн акт боловч цаг хугацааны явцад нийгмийн харилцааны хөгжил, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн шинэчлэл болон хүний эрхийн олон улсын стандартын шаардлагатай бүрэн нийцэхгүй болсон нь уг зохицуулалтын үр нөлөөнд тодорхой хэмжээгээр сөргөөр нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, сэжигтнийг баривчлах болон цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалт хангалтгүй, цагдан хоригдсон этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгаа тодорхой бус, мөн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, заавар хүчингүй болсон эсхүл шинэчлэгдээгүйгээс эрх зүйн хийдэл үүсэх нөхцөл бүрдсэн гэж үзэж байна. Түүнчлэн цагдан хоригдсон хүний хяналтын тогтолцоо болон хариуцлагын механизм тодорхой бус

нарийвчилсан зохицуулалт шаардлагатай нь практикт ажиглагддаг бөгөөд энэ нь хүний эрхийг хамгаалах олон улсын эрх зүйн стандарттай бүрэн нийцүүлэх шаардлага үүссэнийг илэрхийлэх төдийгүй уг хуулийг цаашид системтэйгээр буюу судалгаанд үндэслэн боловсронгуй болгох, шинэчлэх эрх зүйн хэрэгцээ, шаардлага бодитойгоор бий болсныг харуулж байна.

Энэхүү судалгаагаар Сэжигтэн яллагдагчийг баривчлах цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-аар судалсан болно.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу энэхүү судалгааг гүйцэтгэж, Сэжигтэн яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

Үүний тулд хуулийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, холбогдох судалгаа, мэдээлэл, ном сурах бичиг, илтгэл, өгүүлэл болон бусад улс орны туршлагыг судлан үзэж, холбогдох статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томъёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судлав.

Эцэст нь тухайн хувилбаруудаас сонгон авч дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999) шинэчлэх хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааг аргачлалын (Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, 2016) 2.1-д заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдоогүй хүний хувийн эрх чөлөөг хязгаарлах шинжтэй, төрөөс хэрэгжүүлдэг албадлагын арга хэмжээний нэг төрөл юм. Өөрөөр хэлбэл, Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурорын санал болгосноор шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ мөн (Г.Совд, 1999) Үүнийг гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг мөрдөн байцаах шатанд хуульд заасан хангалттай үндэслэлтэй нөхцөлд хэрэглэдэг хамгийн хатуу арга хэмжээ болдог.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зохих ял шийтгэлийг оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах зорилттой. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах нь төрийн хүсэл зориг давамгайлсан албадлагын шинжтэй байдаг тул энэ арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүний эрх хөндөгдөж байдаг. Түүний дотор таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг бол сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зугтаалгахгүй, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох, ЭХХШ ажиллагааг хуулийн дагуу явуулахад саад хийлгэхгүй, цаашид гэмт хэрэг шинээр үйлдэх бололцоо олгохгүй байх зорилгоор тэдний хувийн эрх, эрх чөлөөг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах тусгайлан тогтоосон албадлагын арга хэрэгсэл бөгөөд хүний үндсэн эрхийг хөндөж хатуу хязгаарлалт тогтоож байдгаараа онцлогтой (Д.Цогтсайхан, 2012).

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйл хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй байх эрхтэй гэж заасан бөгөөд 9 дүгээр зүйлд хэнийг ч дур мэдэн баривчлах, хорих эсхүл хөөн зайлах ёсгүй гэж тунхагласан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ гэж заасан (Монгол Улсын Үндсэн хууль, 1992).

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны таслан сэргийлэх арга хэмжээний хүрээнд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хуульд заасан үндэслэл, журам, хугацааны дагуу шүүхийн шийдвэрээр цагдан хорих байр, төвд түр саатуулах зохицуулалттай.

Өөрөөр хэлбэл, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь хүний халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрхэд шууд хязгаарлалт тогтоодог тул түүнийг хэрэглэх үндэслэл, нөхцөл, журам, хугацааг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд нарийвчлан зохицуулсан

байдаг. Өөрөөр хэлбэл, шүүх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу яллагдагч этгээдийг дараах нөхцөл байдал бий гэж үзвэл цагдан хорих шийдвэр гаргадаг. Үүнд :

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан;

- Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

- эд хөрөнгө, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа насанд хүрээгүй хүний эсрэг, эсхүл амь нас, эрүүл мэнд, бусад шалтгааны улмаас өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

- гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

- урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл бүрддэг байна (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017).

Мөн эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болох зохицуулалттай.

Дээрх эрх зүйн зохицуулалтыг үндэслэн цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт болох 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлан мөрдүүлж эхэлсэн Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль юм. Уг хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх харилцааг зохицуулдаг бөгөөд нийгмийн харилцааны хөгжил, эрүүгийн процессын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэхэд тодорхой хүндрэл, бэрхшээл үүсээд байгааг дээр дурдсан бөгөөд энэхүү тандан судалгаагаар бид энэхүү асуудалд дүн шинжилгээ хийхийг зорьсон болно.

1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн цаг үе, эрх зүйн шинэтгэлийг даган шинэчилсэн найруулга хийх хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тандан судлах, тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд анхаарал татаж байна. Үүнд:

- Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай юу эсхүл шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага үүссэн эсэх.
- Цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэхэд тулгарч буй зохицуулагдаагүй харилцааг тодорхойлох, бусад улс оронд цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлах.
- Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх хүний эрхийг хангах, цагдан хоригдогчийн эрх, үүрэг, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульчлах талаар асуудал.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой гэж судалгааны баг үзсэн.

2017 оны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудыг Улсын Их Хурлаас шинэчлэн найруулан баталсан. Энэхүү эрх зүйн шинэтгэлийн хүрээнд орхигдсон буюу нэмэлт өөрчлөлт орох байдлаар үлдсэн хууль бол Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль юм.

Энэхүү 1999 оны хуулийн үйлчлэлийн хүрээнд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг дараах эх сурвалжаар /хууль/, үүнд, (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017), (Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999), (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017); **эрх зүйн акт** Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайдын дангаар болон хамтран гаргасан тушаал, тухайлбал, Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгчийн 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дүгээр тушаалаар баталсан (Хорих байрны дотоод журам, 2017), Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07-р сарын 31-ний өдрийн А/214 дүгээр тушаалаар баталсан Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хоригдлыг хоногийн хүнсээр хангах, хоногт авбал зохих илчлэг норм, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 7-р сарын 25-ны өдрийн А/197 дугаар баталсан Хорих ангийн Харуул хамгаалалтын журам, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 09-р сарын 07-ны өдрийн А/236, А/104 дүгээр хамтарсан тушаалаар баталсан Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл журам, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 07-р сарын 18-ны өдрийн А/192, А/81 дүгээр хамтарсан тушаалаар баталсан Хорих байгууллагын алба хаагчийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн тойрог тогтоох журам, Хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын 2017 оны 09-р сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 10-р сарын 18-ны өдрийн

А/260, А/112 дугаар хамтарсан тушаалаар баталсан ШШГБ-ын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам, Хууль зүй дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 09-р сарын 06-ны өдрийн А/225, А/101 дүгээр хамтарсан тушаалаар баталсан Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх, мэдээлэх журам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайдын 1999 оны А/26.10 дугаар тушаалаар баталсан Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар, Эрүүл мэнд, спортын сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 59, А/67 тоот тушаалаар Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн ажилтан ирж үйлчлэх журам зэрэг эрх зүйн актыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгааг дурдах нь зүйтэй юм.

Тэгвэл Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд зааснаар баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэлийг заахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл болно гэж заасан.

Харин Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд гаргах шийдвэрийн хэлбэрийг хуульчилсан бөгөөд мөн зүйлийн 22.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.4-т зааснаас бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэл нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллага, албан тушаалтны шүүхээр баталгаажуулсан шийдвэр байна” гэж тус тус заасан.

Гэтэл 2023-2025 оны хооронд нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 27, нийт 28 цагдан хорих байранд 4451 хүн хоригдсоны 40.5 хувь буюу 1804 хоригдогч нь мөрдөгч, прокурорын тогтоолоор баривчлагдан цагдан хорих байранд хүргэгдэн ирж хоригдсон гэсэн тоо баримт байна.

Баривчлах гэдэг нь хорих ажиллагааны эхлэл болох ба зөвхөн хуулиар зөвшөөрсний дагуу явагдана. Хууль ёсны байх шаардлагыг хангах үүднээс баривчлах ажиллагаа ямагт шүүхийн зөвшөөрөл ба хяналтад явагдах ёстой гэж заадаг бөгөөд баривчлагдсан хүмүүсийн тоо бүртгэлийг харийн хөтлөх нь хүн сураггүй болохоос сэргийлэх ба шүүхийн хяналт үр нөлөөтэй байхын маш чухал нөхцөл юм гэж

Шигтгээ 1.

“...аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хяналт шалгалт явуулахад хуульд заагаагүй “мэдэгдэл” гэх баримт бичигт үндэслэн цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлсэн, шүүгчийн захирамжид цагдан хорих арга хэмжээг хэрэгжүүлэх цагдан хорих байр, хэрэгжүүлэх албан тушаалтныг тодорхой заагаагүй, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгчид мэдэгдэх талаар дурдаагүй байсан...”

(Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний зөвлөмжөөс, 2024)

Дээр дурдагдсан асуудал нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан үндэслэл,

журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл болно гэсэн заалтын агуулга буюу эрх бүхий албан тушаалтан гэдгийг тайлбарлаагүйтэй холбоотой бөгөөд хуульд шүүх, шүүгчийн гэж зааж өгөх нь зүйтэй байна.

Хуульд нарийвчлан тусгаж өгөөгүйтэй холбоотойгоор Монгол Улсын нэгдэн орсон баримт бичгүүд зөрчигдөх хүний эрхийн зөрчил гарах үндэс болж байна. тухайлбал, Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан хүн бүр эрх чөлөөтэй болон халдашгүй дархан байх эрхтэй. Хуулиар тогтоосон үндэслэл болон журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй.

Америкийн конвенц 7-р зүйл шүүхийн шийдвэргүйгээр хэнийг ч дур мэдэн баривчлах ба хорьж болохгүй.

Европын конвенц 5(1) Хуулиар тодорхойлсон журам ба дараах тохиолдлуудаас гадуур хэний ч эрх эрх чөлөөг хасаж болохгүй. Тухайлбал, эрх бүхий шүүхээр шийтгүүлсэн хүнийг хууль ёсоор хорих, шүүхийн хууль ёсны шийдвэрийг хэрэгжүүлэх, хуулиар тодорхойлсон аливаа үүргийг биелүүлэхийн тулд хүнийг хууль ёсоор баривчлах ба хорих гэсэн заалтууд зөрчигдөж байна.

Цагдан хорихтой холбогдох тулгамдсан асуудлуудын мөн чанар

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас урьдчилан хорих нөхцөл, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч олон улсын түвшинд урьдчилан хоригдогчид нь шоронгийн тогтолцооны хамгийн дорой, тааруу нөхцөл бүхий хэсгүүдэд хоригдсоор байна. Эдгээр хорих байр нь хэт ачаалалтай, хуучирч муудсан, ариун цэвэр, эрүүл ахуйн наад захын шаардлага хангахгүй, хүний амьдрах орчинд үл нийцэх тохиолдол түгээмэл байна (Хүний эрхийн дээд комиссарын газар /Орч. Д.Зүмбэрэлхам/, 1994).

Мөрдөн байцаалт болон шүүхийн шатанд хоригдогчид олон сар, зарим тохиолдолд хэдэн жилээр хоригдох явдал ажиглагддаг бөгөөд тэдний хэргийг шуурхай шийдвэрлэх, эрхийг нь хамгаалах чиг үүрэг бүхий тусгайлсан институт, албан тушаалтны зохицуулалт хангалтгүй байх нь нийтлэг байна. Үүнээс шалтгаалан урьдчилан хоригдох хугацаанд хоригдогчдыг боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт зэрэг сэтгэлзүй, нийгмийн дэмжлэг үзүүлэх боломж хомс байдаг.

Үүний зэрэгцээ урьдчилан хоригдогчид нийгмийн харилцаанаас тасарч, гэр бүл, ойр дотнын хүмүүсээсээ тусгаарлагдсанаар сэтгэл зүйн хүнд дарамт, хямралд өртөх нь элбэг байна. Шүүхийн шийдвэрээ хүлээж, ирээдүй нь тодорхойгүй байгаа нөхцөл байдал нь тэдэнд сэтгэлзүйн өндөр ачаалал үүсгэдэг. Мөн мөрдөн байцаалтын шатанд тэд зүй бус харьцаанд өртөх, өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрөх мэдүүлэг өгөхөд албадуулах эрсдэл бүхий орчинд байж болзошгүй гэж хүний эрхийн байгууллагаас үздэг.

СЯБЦХШБТХ-д заасан хорих өрөөнд тавигдах шаардлага буй орчин нөхцөл

Хуульд хоригдсон этгээдийн байрлах өрөө нь төмөр хаалгатай, онгойлгох хязгаарлагчтай, хяналтын шагайвартай, гадна талдаа цоожтой, цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, модон шалтай, эсхүл модон наартай байх бөгөөд хорих өрөөний чийглэг 55-60 хувь, өвлийн улиралд 18 хэмээс багагүй дулаантай байна гэж заасан. Харин ШШГТХ-д хорих өрөөнд тавигдах шаардлагыг олон улсын стандартад

нийцсэн байна гэж заасан зэрэгт харьцуулан шинжилгээ хийж үзвэл дараах дүгнэлтэд хүрч байна.

Хорих өрөөнд тавигдах дээрх СЯБЦХШБТХ-д заасан зохицуулалтыг олон улсын хүний эрхийн стандарттай харьцуулан үзэхэд тодорхой хэмжээнд нийцэж байгаа хэдий ч зарим чухал шаардлагуудыг бүрэн тусгаагүй, хүний эрхэд суурилсан хандлага дутмаг байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, хорих өрөө нь агааржуулах салхивчтай, тодорхой хэмжээний дулаан өвлийн улиралд 18 хэмээс доошгүй, чийгшлийн түвшин 55–60 хувийг хангах ёстой гэж заасан нь эрүүл ахуйн суурь нөхцөлийг хангах чиглэлээр Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэмд заасан шаардлагатай тодорхой хэмжээнд нийцэж байна. Гэсэн хэдий боловч СЯБЦХШБТХ-д заасан зохицуулалт нь ихэвчлэн хорих өрөөний аюулгүй байдлыг хангах төмөр хаалга, сараалжин цонх, цоож, хяналтын шагайвар гэх мэт техникийн шинжтэй шаардлагад төвлөрсөн бөгөөд хүний нэр төр, эрүүл мэнд, сэтгэл зүйн байдалд шууд нөлөөлөх орчны стандартуудыг хангалттай тусгаагүй зохицуулалт болсон гэж үзэх үндэслэлтэй байна.

Тухайлбал, олон улсын стандартад хоригдол бүрд ногдох амьдрах талбайг тодорхой зааж, хэт дүүргэлтээс сэргийлэхийг шаарддаг. Мөн байгалийн гэрэлтүүлэг хангалттай байх, унших боломжтой гэрэлтэй байх шаардлагыг олон улсын баримт бичигт тодорхойлсон байдаг боловч үндэсний зохицуулалтад зөвхөн сараалжин цонхтой байхыг заасан нь гэрэлтүүлгийн чанар, хүрэлцээг хангах талаарх баталгааг бүрдүүлээгүй байна. Үүнээс гадна ариун цэврийн байгууламжийн шаардлага, хувийн нууцыг хангах асуудал, тусдаа ор, цэвэр хэрэглэл бүхий унтах орчны стандарт зэрэг хүний нэр төр, эрүүл ахуйн суурь нөхцөлүүдийг огт тусгаагүй нь олон улсын шаардлагатай нийцэхгүй зохицуулалт гэж үзсэн.

Иймд дээрх зохицуулалтыг дүгнэхэд хорих өрөөний аюулгүй байдал, техникийн нөхцөлийг тодорхой хэмжээнд хангахыг зорьсон боловч хүний эрх, нэр төр, эрүүл мэндэд суурилсан орчны стандартыг бүрэн тусгаагүй, ялангуяа амьдрах орчны чанарын үзүүлэлтүүдийг орхигдуулсан нь эрх зүйн зохицуулалтын сул тал гэж үзэх үндэслэлтэй байна. Өөрөөр хэлбэл, хүний эрхийг хангах чиглэлээрх олон улсын баримт бичигт тусгагдсан агуулга буюу хоригдсон хүнтэй хүнлэг, нэр төрийг нь хүндэтгэн харьцах гэсэн зарчимтай нийцэхгүй байх бөгөөд хүний эрхийн зөрчил үүсэж болзошгүй тул цаашид энэхүү хуулийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна.

Шигтгээ 2.

“ШШГЕГ-ын харьяа цагдан хорих байрны орчин нөхцөлийг сайжруулах, хоригдогсдын хоол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах, эргэлт, уулзалт, өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах орчин нөхцөлийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг шат дараатайгаар хийж байгаа нь сайшаалтай. 2024 оны байдлаар нийслэлд цагдан хорих төв 1, орон нутагт 27, нийт 28 цагдан хорих байр үйл ажиллагаа явуулж байгаагаас орчин нөхцөлийг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор барилга байгууламжийн 78.6 хувийг үе шаттайгаар шинэчилж, шинээр барьсан бол цаашид 6 аймаг, дүүргийн цагдан хорих байрыг шинэчлэх шаардлагатай. Тухайлбал 2016-2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Архангай, Хөвсгөл, Өвөрхангай, Ховд, Завхан аймгийн Тосонцэнгэл сум, Сэлэнгэ аймгийн Сайхан сум, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь

цагдан хорих байрны барилгыг шинээр барьж, ашиглалтад оруулсан бол 2024 онд Хэнтий, Төв аймаг дахь цагдан хорих байрыг шинээр барьж ашиглалтад оруулжээ.

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний санаачилгаар 2024 онд ШШГЕГ-ын харьяа Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Хөвсгөл, Сүхбаатар, Дулган, Дорноговь, Завхан, Өмнөговь, Баянхонгор аймгууд дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Цагдан хорих байранд удирдамжтай хяналт шалгалт, 21 аймгийн цагдан хорих төвд урьдчилан сэргийлэх үзлэг явуулсан.

Шалгалтын үр дүнгээр Баян-Өлгий, Дархан-Уул, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байр, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Нийслэлийн Багануур дүүрэг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн цагдан хорих байр холбогдох стандартад заасан шаардлагыг хангахгүй байгааг нэн даруй шинэчлэх шаардлагатай байна.

Цагдан хорих байрны стандарт хангагдаагүйгээс нэг хүнд ноогдох талбайн хэмжээ, ариун цэврийн байгууламж, усанд орох газар, агаарын сэлгэлт, хоол бэлтгэх хэсэг, эргэлт, уулзалт хийх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах өрөө, алба хаагчийн хөдөлмөрийн нөхцөл зэрэг хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудал түгээмэл болжээ. Комисст 2024 онд нийт 1311 гомдол, мэдээлэл ирснээс 360 гомдол, мэдээлэл буюу 27.5 хувь нь цагдан хорих төв, хорих ангиудаас ирсэн ба 7 удаагийн хяналт шалгалт хийж, 4 зөвлөмж хүргүүлээд байна.”

(Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний зөвлөмжөөс, 2024)

Цагдан хоригдсон хүний аюулгүй байдлыг хангах

СЯБЦХШБТХ-д хоригдсон этгээдийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан, хоригдсон бусад этгээдийн зүгээс түүнд заналхийлсэн, довтолсон тохиолдолд хорих байрны ажилтан хоригдсон этгээдийн хувийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ цаг алдалгүй авах үүрэгтэй гэж хуульчилсан.

Энэхүү зохицуулалт нь хоригдсон этгээдийн амь нас, эрүүл мэндийн хамгаалалтыг төрийн байгууллага, алба хаагчид шууд үүрэг болгон тогтоосон агуулгатай бөгөөд хүний эрхийн суурь зарчимд нийцсэн, эерэг ач холбогдолтой заалт юм. Тодруулбал, хорих байрны ажилтанд тухайн этгээдийн эсрэг гарч болзошгүй халдлага, аюул заналхийлэл, хүчирхийллийн нөхцөл байдал үүссэн даруйд цаг алдалгүй хамгаалалтын арга хэмжээ авах үүрэг хүлээлгэснээр хоригдсон хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахыг зорьж байгаа зохицуулалт юм.

Гэвч энэхүү зохицуулалтын хэрэгжилтийн үр нөлөө нь “цаг алдалгүй арга хэмжээ авах” гэсэн ерөнхий томъёоллоос шалтгаалан практикт тодорхой байдлаар хэмжигдэх, үнэлэгдэх шалгуур дутмаг байж болзошгүй юм. Иймд ирээдүйд энэ төрлийн заалтыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн үнэлгээ хийх журам, хамгаалалтын арга хэмжээний шатлал, хариуцлагын тодорхой механизмыг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж болох бөгөөд уг зохицуулалт нь хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах үндсэн зарчмыг хуульчилсан эерэг зохицуулалт боловч түүний хэрэгжилтийг илүү тодорхой, хэмжигдэхүйц болгох замаар хүний эрхийн хамгаалалтын баталгааг бэхжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн цагдан хорих байрны дотоод дэг журам, зохион байгуулалт сул байх, хоригдогчдын байнгын шилжилт хөдөлгөөн, хорих өрөөнд хуваариалан байрлуулах тогтолцоо хангалтгүй зэрэг нь сул дорой хоригдогчдыг бусдын хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг. Албан ёсны хяналт, хамгаалалтын механизм сул байгаа нь дэг журам сахиулах, аюулгүй байдлыг хангахад хүндрэл учруулж байна.

Дээрх нөхцөл байдал, статистик үзүүлэлтүүдээс харахад урьдчилан хорих ажиллагааны хүрээнд тоон өсөлт ажиглагдаж байгаа нь цагдан хорих байрны ачаалал, аюулгүй байдал, дотоод зохион байгуулалтад сөрөг нөлөө үзүүлж байна. Улсын хэмжээнд Улаанбаатар хот болон орон нутгийн 28 цагдан хорих төв, байранд нийт 1477 хоригдогч байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 139, өсвөр насны 32 хүн хоригдож байгаа бөгөөд сүүлийн гурван жилийн дунджаар 4451 хүн цагдан хоригдсон нь уг таслан сэргийлэх арга хэмжээ өргөн хэрэглэгдэж байгаагийн илрэл юм. Энэ нь нэг талаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хэрэглээ өндөр байгааг, нөгөө талаас цагдан хорих төв, байрны хүчин чадал, нөхцөлд хүндрэл үүсгэж байгааг харуулж байна.

Хүснэгт 1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хордогсдын тоон үзүүлэлт

Д/д	Цагдан хорих байр	2023 он	2024 он	2025 он	3 жилийн дундаж тоо	Мөрдөгч, Прокурорын тогтоолоор хоригдсон хоригдогчийн тоо
1	Мандал сум дахь ЦХБ	32	41	44	117	5
2	Хэнтий аймаг дахь ЦХБ	29	36	43	108	24
3	Хархорин сум дахь ЦХБ	35	42	52	129	8
4	Говьсүмбэр аймаг дахь ЦХБ	8	7	8	23	3
5	Багануур дүүрэг дахь ЦХБ	38	46	57	141	8
6	Орхон аймаг дахь ЦХБ	17	14	26	57	56
7	Дархан -Уул аймаг дахь ЦХБ	67	73	78	218	15
8	Ховд аймаг дахь ЦХБ	17	20	29	66	9
9	Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги	368	422	672	1462	1372
10	Архангай аймаг дахь ЦХБ	57	64	59	180	21
11	Баян-Өлгий аймаг дахь ЦХБ	52	65	54	171	16
12	Баянхонгор аймаг дахь ЦХБ	26	21	28	75	18
13	Булган аймаг дахь ЦХБ	13	11	17	41	3
14	Говь-Алтай аймаг дахь ЦХБ	10	14	18	42	8
15	Дорнод аймаг дахь ЦХБ	119	134	151	404	21
16	Дорноговь аймаг дахь ЦХБ	28	34	28	90	64

17	Дундговь аймаг дахь ЦХБ	51	58	49	158	18
18	Завхан аймаг дахь ЦХБ	27	35	35	97	6
19	Тосонцэнгэл сум дахь ЦХБ	8	7	11	26	Байхгүй
20	Өвөрхангай аймаг дахь ЦХБ	49	37	45	131	Байхгүй
21	Өмнөговь аймаг дахь ЦХБ	51	54	55	160	14
22	Ханбогд сум дахь ЦХБ	49	57	42	148	Байхгүй
23	Сүхбаатар аймаг дахь ЦХБ	21	17	15	53	17
24	Сэлэнгэ аймаг дахь ЦХБ	14	17	14	45	8
25	Сайхан сум дахь ЦХБ	24	22	25	71	11
26	Төв аймаг аймаг дахь ЦХБ	41	46	45	132	50
27	Увс аймаг дахь ЦХБ	14	18	21	53	8
28	Хөвсгөл аймаг дахь ЦХБ	16	19	18	53	21
НИЙТ		1281	1431	1739	4451	1804

Энэхүү тоон үзүүлэлтээс харахад шүүхийн практикт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдол нэмэгдэж байгаа бөгөөд жилд дунджаар 3.4-6.9 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Цагдан хоригдогчдын тоо нэмэгдэхийн хэрээр дотоод аюулгүй байдал, сахилга, зохион байгуулалтын асуудал хурцаар тавигдаж байна. Сүүлийн таван жилийн хугацаанд цагдан хоригдсон этгээдүүдийн дунд нийт 327 зөрчил, 4 гэмт хэрэг бүртгэгдсэн нь хорих байрны дотоод журам зөрчих, алба хаагчийн шаардлагыг эсэргүүцэх, хамт хоригдож буй хоригдогчидтой маргалдах, зодолдох зэрэг зөрчил давамгайлж байгаатай холбоотой юм. Энэ нь зөвхөн хоригдогчдын зан үйлтэй холбоотой асуудал бус, харин эрх зүйн зохицуулалт, дотоод хяналтын механизм, сахилгын хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгааг илтгэх шинжтэй байна. Ялангуяа цагдан хоригдсон хүний эрх, үүргийг тодорхой, хэрэгжихүйц байдлаар зохицуулах, зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага тулгарч байна. Тухайлбал, СЯБЦХШБТ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13-т зааснаар цагдан хоригдсон хүн хорих байрны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах асуудлыг хуульчилсан бөгөөд ХЗДХ-ийн сайдын баталсан Хорих байрны дотоод журмын 12 дугаар зүйлийн 12.4.1-д зааснаар хорих байрны даргын баталсан хуваарийн дагуу насанд хүрсэн хоригдсон этгээдийг 7 хоногт хоёр удаа тус бүр 30 минутаас багагүй хугацаагаар салхилуулж, хамгаалалтын ажилтнууд хяналт тавина, хоригдсон эмэгтэйчүүдийг 7 хоногт дөрвөн удаа тус бүр 30 минутаас багагүй хугацаагаар, жирэмсэн эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хоригдсон этгээдийг өдөр бүр 1 цагаас доошгүй хугацаагаар салхилуулах талаар заажээ.

Харин СЯБЦХШБТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9-д сахилгын зөрчил гаргасан этгээдийг сахилгын өрөөнд ганцаарчлан хорих бөгөөд ийм этгээдийг өдөрт 15 минут, өсвөр насны хүнийг өдөрт 30 минут салхинд гаргана гэж заасан нь дээрх ердийн буюу зөрчил гаргаагүй хоригдогсодтой харьцуулахад илүү, тогтмол давтамжтай салхилуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтын хувьд сахилгын зөрчил гаргасан этгээдэд бодит байдал дээр давуу нөхцөл үүсэж байгаа зөрчилдөөнтэй

байдлыг илэрхийлэх бөгөөд холбогдох зохицуулалтыг уялдуулах, хууль, журмын нийцлийг хангах шаардлагатайг харуулж байна.

Нөгөөтээгүүр цагдан хоригдсон этгээдийн эрхийг хуулиар бус, захиргааны шинжтэй журмаар зохицуулж байгаа нь эрх зүйн хувьд зөрчилдөөнтэй асуудал гэж үзэх үндэслэлтэй. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой аливаа зохицуулалт нь заавал хуульд үндэслэсэн, тодорхой, ойлгомжтой, урьдчилан таамаглах боломжтой байх ёстой гэсэн эрх зүйн суурь зарчим үйлчилдэг. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан “хууль дээдлэх” болон “хүний эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлах” зарчимтай шууд холбоотой.

Цагдан хоригдсон этгээд нь эрх зүйн хувьд бүрэн эрхээ алдаагүй, зөвхөн тодорхой хүрээнд эрх нь хязгаарлагдсан субъект байдаг тул түүний эдлэх эрх, хүлээх үүрэг, түүнд тавих хязгаарлалт, сахилгын хариуцлагын төрөл, хэлбэрийг хууль тогтоомжийн түвшинд тодорхой тусгах шаардлагатай. Харин эдгээр суурь харилцааг журмаар нарийвчлан зохицуулах нь зөвшөөрөгдөх боловч эрхийн агуулгыг шинээр бий болгох, хязгаарлах, эсхүл өргөтгөх байдлаар журам нь хууль орлох шинжтэй болох нь эрх зүйн хувьд зохимжгүй юм.

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээний хүрээнд ч энэ шаардлага адил үйлчилдэг. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын “Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрэм” (Nelson Mandela Rules)-д хоригдлын эрх, нөхцөл, дэглэмийг тодорхой, ил тод, хууль зүйн үндэслэлтэйгээр тогтоохыг шаарддаг. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дурдсанаар хэнийг ч дур мэдэн баривчлах, хорихыг хориглож, эрхийг нь хязгаарлах аливаа арга хэмжээ нь хуульд нийцсэн байх ёстой гэж заасан байдаг.

Иймээс цагдан хоригдсон этгээдийн эрх, үүрэг, хязгаарлалт, хариуцлагын үндсэн зохицуулалтыг хууль тогтоомжийн түвшинд иж бүрэн тусгах, харин түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг доод шатны эрх зүйн актаар зохицуулах нь хүний эрхийн баталгааг хангах, эрх зүйн зөрчилдөөнөөс сэргийлэх үндсэн нөхцөл болно.

Цагдан хорих байранд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх

СЯБЦХШБТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дугаар зүйлд зааснаар цагдан хоригдсон хүн нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан журмын дагуу авах эрхтэй гэж заасан боловч энэхүү хууль нь 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсон байх бөгөөд Эрүүл мэндийн даатгалын тухай шинэчилсэн найруулгатай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

СЯБЦХШБТХ-ийн 25 дугаар зүйлд эмнэлэг, эрүүл ахуйн хангамжийн талаар зохицуулсан бөгөөд 25.1-д хорих байранд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу явуулах, мөн хорих байрны захиргаа нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүрэгтэй гэж заасан нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалах төрийн эерэг үүргийг тодорхойлж байна. Энэ нь хүний нэр төр, эрүүл мэндийг хамгаалах талаар олон улсын стандартад заасан шаардлагатай нийцэж байгаа бөгөөд хоригдсон этгээдийг бусад иргэдийн адил эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эрхтэйг баталгаажуулсан зохицуулалт гэж үзэж болно.

Мөн хуулийн 25.2-т эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд энгийн эмнэлгийн байгууллагад эмчлүүлэх боломжийг нээж өгсөн нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийн тусламж авах эрхийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн бөгөөд хорих орчны

хязгаарлалтаас үүдэн эмчилгээ тасалдах эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. 25.3-т хоригдсон этгээд гэмтэл авсан тохиолдолд заавал эмнэлгийн үзлэг хийж, дүнг баримтжуулан танилцуулах, мөн түүний өөрийн болон өмгөөлөгчийн хүсэлтээр хараат бус эмнэлгийн байгууллагаар үзлэг хийлгэх боломжийг олгосон нь эрүүдэн шүүх, хүчирхийллээс хамгаалах, тийм үйлдэл гарсан эсэхийг нотлох чухал баталгаа болдог.

Түүнчлэн 25.4, 25.5-д хоригдсон этгээд хүндээр өвдөх, нас барах тохиолдолд ойрын төрөл саданд нь нэн даруй мэдэгдэх, нас барсан тохиолдолд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийлгэх, улмаар ар гэрт нь шилжүүлэх, эсхүл оршуулгыг зохион байгуулах талаар заасан нь хүний амь нас, нэр төрийг хүндэтгэх, мөн ар гэрийн мэдээлэл авах эрхийг хангах зохицуулалт юм.

Шигтгээ 3.

Хорих байгууллага, цагдан хорих байр, албадан саатуулах байранд хүн /хоригдол, хоригдогч/ нас барсан тохиолдол 2022 онд 6, 2023 онд 4, 2024 онд 7, хүний эрүүл мэнд хохирсон тохиолдол 2022 онд 12, 2023 онд 20, 2024 онд 18 бүртгэгдэж хуулийн дагуу шалгах ажиллагаа явуулжээ.

Гэсэн хэдий ч эмнэлгийн тусламж үзүүлэхтэй холбоотой эдгээр зохицуулалт нь ерөнхий шинжтэй байгаа бөгөөд практикт хэрэгжилтийг хангах нарийвчилсан стандарт, хяналтын механизм, эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, чанарын баталгааг илүү тодорхой болгох шаардлага байна. Ялангуяа хоригдсон хүнд үзүүлэх эмнэлгийн тусламж нь иргэний эрүүл мэндийн үйлчилгээтэй дүйцэх түвшинд байх, хараат бус байдлыг хангах, эмнэлгийн нууцлал, зөвшөөрлийн зарчмыг хэрэгжүүлэх асуудлыг илүү нарийвчлан зохицуулах нь хүний эрхийн хамгаалалтыг бодитой хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Иймд энэхүү зохицуулалт нь хоригдсон этгээдийн эрүүл мэнд, хүний эрхийг хамгаалах суурь чиглэлийг тодорхойлсон боловч түүнийг илүү боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцүүлэх шаардлага байгааг харуулж байна. Ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний онцлог хэрэгцээг хуульд нарийвчлан, иж бүрнээр тусгаагүй нь эрх зүйн зохицуулалтын хийдэл гэж үзэх үндэслэлтэй.

Хэдийгээр хуулийн 30 дугаар зүйлд хоригдож байгаа жирэмсэн эмэгтэйг ахуйн нөхцөлийн хувьд сайжруулсан байранд байрлуулах, эмчийн байнгын хяналтад байлгах, хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлэх, өдөр тутам дор хаяж нэг цаг ба түүнээс дээш хугацаагаар салхинд гаргах, мөн сахилгын байранд хорихыг хориглох зэрэг зохицуулалтыг тусгасан нь тухайн бүлгийн онцлог хэрэгцээг тодорхой хэмжээнд харгалзан үзсэн эерэг алхам юм.

Гэвч эдгээр заалт нь ерөнхий шинжтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээний төрөл, хүртээмж, чанар, төрөлжсөн эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, төрөх үеийн болон төрсний дараах асаргаа сувилгааны стандартыг нарийвчлан зохицуулаагүй байна. Иймд жирэмсэн хоригдогч эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хангах үүднээс холбогдох зохицуулалтыг илүү дэлгэрүүлж, олон улсын хүний эрхийн стандарттай уялдуулах шаардлагатай байна.

Шигтгээ 4.

Цагдан хорих 461 дүгээр ангид 2024 онд нийт 20 жирэмсэн эмэгтэй цагдан хоригдсоноос давхардсан тоогоор 19 эмэгтэйг жирэмсний хяналтын үзлэгт хамруулж, 3 эмэгтэйг гадна эмнэлэгт хэвтүүлж, жирэмсэн эмэгтэйн ураг өсөлтгүй болсон тул ургийг авхуулах ажилбарыг мэргэжлийн эмнэлэгт хийлгэсэн байна. Тухайн онд ангийн эмнэлэгт давхардсан тоогоор 12 жирэмсэн эмэгтэй хэвтэн эмчлүүлжээ. 2025 оны 03 дугаар сарын байдлаар 4 жирэмсэн эмэгтэй цагдан хоригдсон байх бөгөөд 3 эмэгтэйг жирэмсний хяналтын үзлэг хамруулж, дутуу зулбасан оноштой 1 эмэгтэйг Амгалан амаржих газарт хэвтүүлж, ургийг авхуулах ажилбар хийлгэжээ. 2024, 2025 онд хоригдож байсан 2 жирэмсэн эмэгтэйг гадна эмнэлэгт хэвтүүлж амаржуулсан байна.

Харин цагдан хоригдсон хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн асуудал зохицуулагдаагүй харилцаа учир практикт хүндрэл үүсгэж байна.

Хорих байрны ажилтан

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270 дугаар зүйлийн 270.7-д зааснаар баривчлах болон цагдан хорих төв, байр, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дэргэдэх мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн болон согтуурах, мансуурах донтох эмгэгтэй этгээдийг албадан эмчлэх байгууллагын ажилтныг хорих байгууллагын алба хаагчтай адилтган үзэх талаар заасан бөгөөд шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, мэргэшил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулахаар заасан.

Түүнчлэн Хорих байгууллагын алба хаагчид тавигдах эрүүл мэнд, бие бялдар, боловсрол, мэргэжил, ёс зүйн шалгуур үзүүлэлт болон хорих байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах журмыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага тогтоохоор заасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн журамд тус байгууллагад ажиллахыг хүссэн иргэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 270 дугаар зүйлийн 270.3-т зааснаас гадна дараах нийтлэг шаардлагыг хангасан байх бөгөөд офицер, ахлагчийн албан тушаалд алба хаагчид тавигдах тусгай шаардлагыг заасан байна (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн журам, 2017).

Гэтэл СЯБЦХШБТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т хорих байрны офицер, ахлагч, түрүүч, байлдагчийг “хамгаалалтын ажилтан” гэж тодорхойлон, тэдгээрт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх, үүргийг эдлүүлэхээр заасан нь эрх зүйн уялдаа, ангиллын хувьд тодорхой зөрчилтэй гэж үзэх үндэслэлтэй байна. Учир нь энэхүү зохицуулалт нь цэргийн албаны эрх зүйн тодорхой байдлын зарчимд нийцэхгүй байна. Тухайлбал, Цэргийн албаны тухай хуульд хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, цол зэрэг, албаны онцлогийг нарийвчлан зохицуулсан бөгөөд уг хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.3-т хугацаат болон гэрээт цэргийн алба хаагч нь “байлдагч”, “ахлах

байлдагч”, “дэд түрүүч”, “түрүүч”, “ахлах түрүүч” зэрэг цолтой байхаар хуульчилсан байдаг (Цэргийн албаны тухай хууль, 2016). Гэтэл СЯБЦХШБТ хуулийн дээрх зохицуулалтаар эдгээр цол бүхий этгээдийг шууд “хамгаалалтын ажилтан” гэж тодорхойлон, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны эрх, үүргийг эдлүүлэхээр заасан нь хоёр өөр эрх зүйн зохицуулалтын хүрээг давхардуулсан шинжтэй байна.

Энэ нь нэг талаас цэргийн алба хаагчийн эрх зүйн статус, сахилга, захирагдах харилцаанд үл нийцэх, нөгөө талаас шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтанд тавигдах шаардлага, эрх, үүргийн онцлогтой зөрчилдөх эрсдэлийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл, нэг этгээдэд зэрэгцэн хоёр өөр эрх зүйн дэглэм үйлчлэх нөхцөл үүсэж, аль хуулийг баримтлах, ямар хариуцлага хүлээлгэх асуудалд тодорхойгүй байдал бий болох боломжтой.

Иймд дээрх зохицуулалт нь хууль хоорондын уялдаа, эрх зүйн тодорхой байдал, системчлэлийн зарчимд нийцүүлэх шаардлагатай бөгөөд цэргийн алба хаагчийг хорих байгууллагын үйл ажиллагаанд оролцуулах тохиолдолд тэдний эрх зүйн статус, чиг үүргийг тусгайлан тодорхойлж, холбогдох хуулиудын зохицуулалтыг уялдуулах замаар зөрчил, давхардлыг арилгах нь зүйтэй байна.

1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох¹

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Хүснэгт 2. Хууль ёсны эрх ашиг зөрчигдөж буй этгээдүүд

№	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1.	Цагдан хоригдсон хүн	Цагдан хорих таслан сэргийлэх тодорхой хугацаагаар хязгаарласан нь олон улсын эрх зүйн баримт бичгийн хүрээнд: - Иргэний болон улс төрийн эрхийн пактад заасан эрх зөрчигдөх буюу шүүхэд цаг тухайд нь хандах эрх саарах, хууль зүйн туслалцаа авах буюу өмгөөлөгчтэй үр дүнтэй харилцах боломж хязгаарлагдах, хорих хугацаа сунгагдаж, эрхээ хамгаалах боломж бодитой багасах - Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцод зааснаар хүчирхийллээс ангид байх эрх баталгаатай хэрэгжихгүй, мэдүүлэг өгөхдөө өөрийгөө хамгаалах байдал сулрах, эрүүл мэндийн тусламж авах эрх хязгаарлагдаж болзошгүй юм. Харин Монгол Улсын Үндсэн хуульд заасан хөдөлмөрлөх, сурч боловсрох, чөлөөтэй зорчих, асран хамгаалах харгалзан дэмжих үүргээ биелүүлж чадахгүй зэрэг зарим эрх хөндөгдөнө. Нөгөөтгээгүүр Цагдан хоригдсон хүний эрх ашиг хөндөгдөж буй асуудал нь зөвхөн эрх чөлөөг хууль ёсоор хязгаарлах явдал бус, харин тухайн этгээдийн эрх, үүргээ бодитоор хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж процессын доголдлын илрэл юм.
2.	Хууль сахиулах байгууллага, Шүүх, прокурор	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан болон цагдан хоригдсон этгээдийн хоорондын харилцаанд хүндрэл үүсэж, хяналт тавих алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа хууль эрх зүйн хувьд нарийвчлан зохицуулагдаагүйгээс шалтгаалан Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажсан хүний эрх, эрх чөлөө бодитоор хөндөгдөх нөхцөл бүрдэж байна.

Дээрх нөлөөллийн улмаас цагдан хоригдсон хүний хувьд Монгол Улсын нэгдэн орсон олон улсын хүний эрхийн хэм хэмжээний баримт бичгүүдэд хүлээсэн үүргийн хэрэгжилт алдагдаж, Монгол Улсын Үндсэн хууль-д баталгаажсан хүний эрх, эрх чөлөө бодитоор хөндөгдөх нөхцөл бүрдэнэ. Үүний зэрэгцээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цагдаа, шүүх, прокурорын байгууллагын ажлын ачаалал нэмэгдэж, хүний нөөц болон төсөв, санхүүгийн хүрэлцээтэй байдлын асуудал үүсэх эрсдэл дагалдан бий болдог.

¹ Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Бидний судалгааны хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээнд оролцогчид тэр дундаа цагдан хорих таслан сэргийлэх хэжээ авагдсан хүн, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид болон бусад хүний эрх ашиг нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн хэрэгжилтэд нөхцөл байдлын шинжилгээ хийж дараах асуудлыг тодорхойлсон болно. Үүнд:

1. Хууль эрх зүйн орчин нь олон эрх зүйн акт, журамд тулгуурласан, харьцангуй өргөн хүрээтэй байгаа боловч тэдгээрийн уялдаа холбоо, хэрэгжилт харьцангуй хангалтгүй буюу сул байна. Тухайлбал, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд цагдан хорих ажиллагааны үндсэн зохицуулалтыг тусгасан ч орхигдсон харилцааг хорих байрны дотоод журам болон ХЗДХ сайдын тушаалаар батлагдсан бусад журамд нөхөж зохицуулж байгаа нь практикт ойлгомжгүй, зөрүүтэй хэрэгжилт бий болгох нөхцөл үүсгэж байна.

2. Цагдан хоригдогчдын тоо жил бүр хэлбэлзэлтэй өсөж, буурч байгаа ч нийтдээ тогтмол өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өргөн хэрэглэж байгааг илтгэнэ. Үүний зэрэгцээ хоригдогчдын гаргасан зөрчил ялангуяа алба хаагчийн шаардлага эсэргүүцэх байдал нэмэгдэж байгаа нь цагдан хорих төв, байранд зохицуулсан дотоод дэглэм журам, алба хаагчийн харилцаа, хандлага, сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйд тулгарч буй олон тулгамдсан асуудал байгааг харуулж байна.

3. Цагдан хорих байрны харуул хамгаалалтын тогтолцоо, техникийн хяналт, хүний нөөцийн норматив шинэчлэгдсэн ч бодит хэрэгжилтэд ачаалал өндөр, хяналтын чанар жигд бус хэвээр байна. Энэ нь аюулгүй байдлын эрсдэлийг бүрэн бууруулж чадахгүй байгааг илтгэнэ.

Асуудал үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг дурдвал Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулиар зохицуулсан харилцаа дутагдалтай учир ХЗДХ сайдын тушаалаар батлагдсан журмаар зохицуулсан харилцаа нэмэгдсэн боловч давхардал, хийдэл их байгааг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй байна. Өөрөөр хэлбэл, цагдан хорих ажиллагаанд тулгамдаж буй асуудал нь зөвхөн нэг хүчин зүйлээс бус, харин эрх зүй, зохион байгуулалт, хүний нөөц, сэтгэл зүй, материаллаг орчны нийлмэл нөлөөллөөс үүдэлтэй системийн асуудал байна. Тэр дундаа эрх зүйн зохицуулалтын уялдаа сул, хүний нөөцийн ачаалал өндөр, хүний эрхийн баталгааны бодит хэрэгжилт хангалтгүй байгаа нь цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны үр нөлөө, аюулгүй байдал, хүний эрхийн хамгаалалтад сөргөөр нөлөөлж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: Хууль эрх зүйн зохицуулалтыг цогц, уялдаатай байдлаар боловсронгуй болгох нь сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөний баталгааг бодитой, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох бөгөөд цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн чанарыг дээшлүүлэхэд оршино.

(Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал. , 2016) 4.1-д бичсэнээр зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томьёолох хэрэгтэй. Бидний тодорхойлсон зорилгын тухайд Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийцүүлэн шинэчлэн найруулах шаардлагатай гэж тодорхойлсон нь тус зорилгыг тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байгааг харуулж байна.

Энэхүү зорилгыг хэмжих боломжийг тодорхойлохдоо хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт, хүний эрхийн баталгаанд үзүүлэх нөлөө гэсэн гурван үндсэн хэмжигдэхүүнээр үнэлсэн бөгөөд дараах байдлаар хэмжигдэхүүнийг гаргасан болно. Үүнд:

1. Эрх зүйн зохицуулалтын боловсронгуй болох үзүүлэлт

-цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой хууль, журмын давхардал, хийдлийн бууралт;

- хууль, цагдан хорих байрны дотоод журмын уялдаа холбооны түвшин;

-олон улсын хүний эрхийн стандарттай нийцсэн байдлын үнэлгээ.

2. Хэрэгжилтийн үр нөлөөг хэмжих үзүүлэлт

- цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарсан хүний эрхийн зөрчлийн тоо буурах

- цагдан хоригдогчийн өмгөөлөгчтэй уулзах, гомдол гаргах зэрэг эрхийн хэрэгжилт

- алба хаагчийн хууль зөрчсөн үйлдлийн давтамж буурах

- шүүх, прокурорын хяналтаар илэрсэн зөрчлийн тоо буурах

3. Хүний эрхийн баталгааны түвшний үзүүлэлт

- хоригдсон хүний эрүүл мэнд, аюулгүй байдал хангагдах

- цагдан хорих нөхцөлийн стандарт орон зай, эрүүл ахуй хангагдах

-хүний эрхийн үндэсний болон олон улсын байгууллагын дүгнэлт эерэг болох

4. Нийтлэг үр дүнгийн үзүүлэлт

-цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны хууль ёсны болон хүний эрхэд нийцсэн байдлын индекс өсөх

-алба хаагч хоригдогчийн харилцааны зөрчлийн бууралт

- хүний эрхийн зөрчилтэй холбоотой шүүх, прокурорын маргааны тоо буурах

Мөн тус зорилго нь аргачлалын 4.2-т зааснаар ерөнхий зорилгод хамаарна. Аргачлалын 4.3-т зааснаар хэрвээ зорилгыг ерөнхий байдлаар тогтоосон тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх зорилт байгаа эсэхийг судлах нь зүйтэй байдаг. Тус зорилгын хүрээнд зорилтуудыг тодорхойлж болохоор байна. Тус зорилго нь тухайлбал, эрх зүйн болон бодит шаардлага бий эсэх, практик нөхцөл байдалд хэрэгжих боломжтой эсэх гэсэн зорилтуудыг агуулж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг эрх зүйн шинэтгэлийн хүрээнд нийцүүлэн шинэчлэх найруулах шаардлагатай” гэсэн зорилгоос гадна хангаж чадах бусад хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 3. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн зохицуулалт одоогийн байгаагаар хэрэгжих ба тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжилнэ.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд үүссэн асуудал хэвээр байх буюу үр өгөөж хэвээрээ байна.	Үр дүн муутай.
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь хязгаарлагдмал. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх нь зохимжгүй буюу хүний эрхийн зөрчилд хүргэж болзошгүй бөгөөд үр дүн сөрөг байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй байдалд хүрнэ.	Үр дүн муутай.
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийснээр үр нөлөө үзүүлэхгүй.	Төрөөс их хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөжгүй байна.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал нь аливаа эрх бүхий этгээдийн санхүүгийн дутагдал, хүндрэлтэй холбоогүй, зөвхөн хуулийн зохицуулалт, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.

5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшил нь шүүхийн таслан шийдвэрлэх шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэгч биш тул үр дүн байхгүй. Харин төрийн болон төрийн бус байгууллага нь цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж ажиллаж болох юм	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт буюу журам, дүрмээр энэхүү харилцааг зохицуулах нь хүний эрхийн зөрчил гарах учир дутагдалтай	Үр өгөөжийн талаар тооцоолох боломжгүй.	Үр дүнгүй.
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах.	Төрөөс хууль батлагдах болон үйл ажиллагаатай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.	Үр дүнтэй.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийснээр тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Дээрхээс дүгнэвэл асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зорилтод хүрэхийн тулд Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулан хуульчлах нь илүү үр дүнтэй хувилбар байна.

Тиймээс “Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ын зорилгыг гүйцэтгэх хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

Хувилбар 1. Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээх замаар асуудлыг шийдвэрлэх;

Хувилбар 2. Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэн найруулан батлуулах замаар цагдан хорих таслан сэргийлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх харилцааг боловсронгуй болгох.

Нэгдүгээр хувилбарын хувьд ямар нэг зохицуулалт хийлгүйгээр одоо байгаа тогтолцооны хүрээнд таслан сэргийлэх бусад арга хэмжээний хэрэгжилт, үр нөлөөг нэмэгдүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх агуулгатай юм.

Хоёрдугаар хувилбар нь Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэн найруулан батлуулах агуулгатай. Ингэснээр цагдан хоригдсон хүний эрхийг хангах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх ач холбогдолтой.

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь оролцогчдын эрх зүйн байдал болон уг ажиллагааг гүйцэтгэх практик онцлог талаасаа ихээхэн анхаарал татаж байдаг эрх зүйн чухал асуудал юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дахь хүний эрхийг хамгаалах, ахуйн нөхцөлийг дээшлүүлэх, түүнчлэн цагдан хорих байранд хүний эрхийн зөрчил гаргахгүй байх шаардлага нь нэлээд өндөр хэмжээнд тавигдах болсон бөгөөд цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал нь тус салбар эрх зүйн онцлох, чухал судлагдахуун байсаар ирсэн.

Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн үндэс нь Монгол улсын Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид тодорхой тусгагдсан бөгөөд энэхүү ажиллагаанд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтлахаас гадна цагдан хорих үндэслэл нь гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан тогтоол, захирамж болохыг заасан байдаг.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бусад хүний эрхийг хангах чиглэлийн баримт бичгүүдэд цагдан хоригдсон хүмүүстэй зөв боловсон харьцах, тэдний эрхийг хүндэтгэх, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон хандах, тэдний эрх зүйн байдлыг ямагт дээшлүүлж, хууль ёсны эрх, аюулгүй байдлыг нь хангаж ажиллах талаар нэлээд дэлгэрэнгүй тусгасан байна.

Тухайлбал: Нэгдсэн үндэсний байгууллагаас гаргасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн тогтолцооны хөтөлбөр нь хоригдох болон хорих ял эдэлж байгаа хүмүүст хандах хандлагын асуудлыг бүхэлд нь авч үзэхдээ цагдан хорих асуудалд гол анхаарлаа төвлөрүүлсэн байдаг.

Мөн шүүхийн өмнөх шатанд цагдан хоригдож байгаа хүмүүстэй холбогдох харилцаа нь “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”, “Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм”-үүд, “Хүүхдийн эрхийн конвенц” буюу “Насанд хүрээгүй хүмүүсийг шүүн таслахтай холбоотой НҮБ-ын наад захын жишиг дүрмүүд”, “Аливаа хэлбэрээр хоригдсон болон саатуулагдсан бүх хүнийг хамгаалах зарчмуудын цогц” зэрэг олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан байна.

2012 онд Хүний эрхийн үндэсний комиссын Монгол улс дахь хүний эрхийн талаар гаргасан 11 дэх илтгэлд НҮБ-ын 1988 онд баталсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” болон “Сэжигтэн яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” Монгол Улсын хуулийн хэрэгжилтийн талаар дурдсан байна. Энэ илтгэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын харьяа хорих анги, баривчлах, цагдан хорих байран дахь хүний эрхийн төлөв байдал, аюулгүй байдлыг хангах талаар тодорхой тусгаж, олон талт зөвлөмж өгсөн нь ихээхэн ач холбогдолтой зүйл болсон юм.

1999 оны 07 дугаар сарын 01-ны өдөр “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” -ийг батлан гаргасан нь цагдан хорих

шийдвэрийг биелүүлэх ажиллагааны талаарх дагнан гаргасан анхны бие даасан хууль болсон юм. Гэвч энэхүү хууль өнөөдрийг хүртэлх хугацаанд нэмэлт өөрчлөлт орох байдлаар шинэчилсэн найруулга хийгдээгүй байна.

Энэхүү нөхцөл байдлыг ерөнхийд нь дүгнэвэл: Монгол Улсад цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь Үндсэн хууль болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд тулгуурлан бүрдсэн боловч суурь зохицуулалт болох 1999 оны хууль өнөөг хүртэл шинэчлэн найруулга хийгдээгүй, зөвхөн хэсэгчилсэн нэмэлт өөрчлөлтөөр зохицуулагдаж ирсэн нь эрх зүйн шинэчлэлийн цогц шинж хангалтгүй байгааг харуулж байна.

Мөн хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрх, нэр төр, аюулгүй байдлыг хангах шаардлага хууль тогтоомжид тусгагдсан хэдий ч түүний хэрэгжилт практикт бүрэн хангагдахгүй, тодорхой сорилт, зөрчил үргэлжилсээр байна.

Иймд цагдан хорих ажиллагааны эрх зүйн орчин нь үндсэн зарчмын хувьд бүрдсэн ч түүнийг хүний эрхийн баталгааг бодитой хангах, олон улсын стандарттай бүрэн нийцүүлэх, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор цогцоор шинэчлэн боловсронгуй болгох бодит шаардлага байсаар байна.

Зорилгод хүрэх байдал:

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хэрэгждэг таслан сэргийлэх арга хэмжээний хамгийн хүнд түвшний арга хэмжээний нэг бөгөөд энэ нь хүний эрх, эрх чөлөөг шууд бөгөөд ноцтойгоор хязгаарладаг, мөн гэм буруутай эсэх нь шүүхээр эцэслэн тогтоогдоогүй этгээдэд урьдчилсан байдлаар хэрэглэгддэг, түүнчлэн шүүхийн эцсийн шийдвэр гарахаас өмнөх шатанд хэрэгждэг онцлогтой учир эрх зүйн онолын хувьд маш өндөр шаардлага, нарийн зохицуулалт шаарддаг харилцаанд хамаардаг.

Энэхүү нөхцөлд уг ажиллагаа нь хууль ёсны байх, зайлшгүй шаардлагатай байх, хамгийн бага хязгаарлалтын буюу хамааралтай байх, хүний нэр төрийг хүндэтгэх, мөн шүүх, прокурорын хяналтад байх гэсэн суурь зарчмуудад зайлшгүй тулгуурлах шаардлагатай бөгөөд эдгээр зарчмууд нь зөвхөн Үндсэн хуулийн хүрээнд бус, харин Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажсан нийтлэг, түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн шаардлага болохын хувьд дотоодын хууль тогтоомжийн агуулгад бүрэн тусгагдах ёстой.

Энэхүү хуулийн өнөөгийн зохицуулалтыг системтэйгээр шинжлэн үзвэл тодорхой давуу талууд байгаа нь харагдах бөгөөд тухайлбал хоригдсон этгээдийн өмгөөлөгчтэй уулзах, эрүүл мэндийн тусламж авах, өргөдөл гомдол гаргах зэрэг суурь эрхүүдийг тодорхой хэмжээнд хуульчилсан, мөн цагдан хорих байрны захиргааны үүрэг, дотоод хяналт, бүртгэлийн тогтолцоог жишиг хэлбэрээр зохицуулсан, түүнчлэн хүч хэрэглэх болон тусгай хэрэгсэл ашиглах нөхцөлийг тодорхой хэмжээнд хуульчлан хязгаарласан, мөн прокурорын хяналтын механизмыг тусгай бүлгээр тусган хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн зэрэг суурь бүтэц бүрдүүлсэн эерэг талуудтай. Гэвч эдгээр эерэг зохицуулалтуудын зэрэгцээ эрх зүйн онол, хүний эрхийн хамгаалалтын стандартын үүднээс тодорхой сул талууд илэрч байгаа бөгөөд тухайлбал сахилгын шийтгэл, тусгаарлалт болон хүч хэрэглэхтэй холбоотой зохицуулалтууд нь зайлшгүй шаардлагын болон хамгийн бага

хязгаарлалтын зарчимтай бүрэн уялдаагүй байдлаар тусгагдсан байх хандлагатай. Учир нь цагдан хоригдсон хүнд хамгийн бага хязгаарлалтын арга хэмжээ хэрэглэх хэрэгжилт сул байна. Мөн одоогийн зохицуулалт нь ихэвчлэн зөрчил гарсны дараах хариу арга хэмжээнд төвлөрсөн шинжтэй байгаа бөгөөд урьдчилан сэргийлэх шинжтэй хамгаалалтын механизм, хүний эрхийн эрсдэлийг бууруулах зохицуулалт харьцангуй сул байгаа нь эрх зүйн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Үндсэн хуулийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах аливаа арга хэмжээ нь зөвхөн хуулиар тогтоогдсон, тодорхой, зайлшгүй шаардлагатай нөхцөлд хэрэгжих ёстой гэсэн зарчмыг илүү нарийвчлан баталгаажуулах, хоёрдугаарт олон улсын эрх зүйн стандарт, ялангуяа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд заасан дур зоргоор баривчлахгүй байх /Мөрдөгч прокурорын тогтоолоор хүлээн авахгүй байх/ зарчим болон 10 дугаар зүйлд тусгагдсан хоригдсон этгээдэд хүнлэг хандах шаардлагыг дотоодын эрх зүйд бүрэн, бодитой тусгах, гуравдугаарт төрийн хариуцлага, хүний эрхийн тэнцвэрийг хангах цогц тогтолцоо гэж үзэх онолын хандлагад нийцүүлэн хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

Эдгээр шинэчлэлийн үр дүнд баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа нь илүү нарийн шалгуур, тодорхой үндэслэлд тулгуурласан эрх зүйн баталгаажсан хязгаарлалтын тогтолцоонд шилжих, хоригдсон этгээдийн эрх зөвхөн зарчим төдий бус бодит хэрэгжилт бүхий баталгаатай механизм болон хөгжих, цагдан хорих хугацаа, үндэслэл, хяналтын тэнцвэр илүү боловсронгуй болох, мөн хараат бус хяналтын суурь тогтолцоо бэхжих нөхцөл бүрдэх бөгөөд ингэснээр уг хуулийн шинэчлэл нь зөвхөн эрх зүйн техникийн засварын шинжтэй бус, харин төрийн албадлагын эрх мэдлийг хүний эрхийн хамгаалалтын зарчимтай тэнцвэржүүлэх шинжтэй суурь шинэчлэл болж, улмаар баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа хууль дээдлэх зарчимд суурилсан, хүний нэр төрийг хамгаалсан, олон улсын эрх зүйн стандарттай нийцсэн орчин үеийн эрх зүйн тогтолцооны түвшинд хөгжих эрх зүйн боломжийг бүрдүүлнэ гэж үзсэн.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Хувилбар 2-т тодорхойлсон байдлаар Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх хуулийг шинэчлэн найруулан хууль батлагдах үйл явцад шаардагдах зардлууд нь улсын төсвөөс гарахаар байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

(Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал. , 2016)-ын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай тул энэ хэсэгт шалгах болно.

Доорх хүснэгтэд зохицуулалтын хувилбаруудын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд хариултын тайлбарыг дэлгэрэнгүй байдлаар тусад нь бичсэн болно.

Хүснэгт 4. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Хувилбар 1	Тийм	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь таслан сэргийлэх арга хэмжээний төрөл нэмэгдэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүний эрх хангагдана.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Хувилбар 1	Тийм	Сэжиглэгдэн шалгагдаж буй эрүүгийн хуулийн зүйлчлэлээ хамаарах
		Хувилбар 2	Тийм	Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг ялгамжтай хэрэглэх магадлалтай
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	НҮБ-ын холбогдох конвенц болон зөвлөмжид нийцсэн.

	хэмжээтэй нийцэж байгаа эсэх			
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Илүү сайжирна.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хүний эрхийг хангах тогтолцоо улам боловсронгуй болно.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	НҮБ-ын Хүний эрхийн конвенц болон хорооны зөвлөмжид нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хариуцлагын тогтолцоо сайжирна.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Хувилбар 1	Үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
		Хувилбар 2	Тийм	Гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох зорилготой
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.

	бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Хувилбар 2	Тийм	Эрх агуулагчдын эрх үүргийг нарийвчлан хүний эрхийн суурь баримт бичигт нийцүүлэн тусгана
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Зорилтод бүлгийн хүний эрхийг дээрдүүлэх хувилбар санал болгоно.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Зорилтод бүлгийн хүний эрхийг дээрдүүлэх хувилбар санал болгоно
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Зорилтод бүлгийн хүний эрхийг дээрдүүлэх хувилбар санал болгоно
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Цагдан хоригдсон хүн болон алба хаагчийн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлно.
5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх

Төрөөс өөрийнхөө харьяалалд байгаа хүн бүрд тэдгээр эрхүүдийг эдлүүлэх нь туйлын чухал юм. "Ялгаварлан гадуурхахгүй байх"-ыг хамгийн эхэнд авч үзэж байгаа нь түүний энэхүү нэн чухал шинж, мөн эмзэг бүлгийн хүмүүсийн эрхийг хэрэгжүүлэхэд ялгаварлан

гадуурхахгүй байх талаар онцгой хүч чармайлт шаардагддаг зэргийг чухалчлан тэмдэглэх зорилготой холбоотой байдаг.

1. Түгээмэл тунхаглал, 2-р зүйл. Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр, арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, утсаа язгуур болон бусад ялгааг эс харгалзан адилхан эрх эдлэх ёстой гэж заасан. Түүнчлэн, тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй буюу олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тэрхүү нутаг дэвсгэр нь тусгаар тогтносон, бусдын асрамжид байгаа, өөртөө захиргаагүй буюу бүрэн эрхт байдал нь өөр ямар ч байдлаар хязгаарлагдсан байсан, хүнийг ялгаварлаж үл болох талаар заасан.

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 2(1)-р зүйлд. Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс, өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, угсаа язгуур болон бусад байдлаар нь ялгаварлахгүйгээр хүндэтгэн эдлүүлэх үүрэгтэй. 26-р зүйлд хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Энэ утгаар аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглосон байх ёстой ба ямар ч шалтгаанаар... ялгаварлан гадуурхахын эсрэг хүн бүр адил тэнцүү бөгөөд үр нөлөө бүхий хамгаалалтын баталгаатай байна.

3. Хорих ажиллагааны зарчмууд 5(2)-р зарчимд. Эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхдээ асарч байгаа эхчүүд, хүүхдүүд, насанд хүрээгүй хүмүүс, хөгшин, өвчтэй, эсхүл тахир татуу хүмүүсийн онцгой байдал ба эрхийг нь тусгайлан хамгаалахад зориулагдсан хуулийн хүрээн дэх арга хэмжээнүүдийг ялгаварлан гадуурхаж байгаа гэж үзэхгүй. Ийм арга хэмжээнүүдийг авах шаардлага ба хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа нь шүүх болон бусад байгууллагын байнгын хяналтад байх ёстой.

4. Наад захын жишиг дүрмүүд, 6(2)-р дүрэмд. Хоригдол нь хүн амын аль ч хэсэгт хамаарч байлаа гэсэн шашин шүтлэг, зан заншлыг нь хүндэтгэх шаардлагатай гэж заасан.

Юуны өмнө, ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх эрхийн суурь агуулга нь ижил нөхцөл байдалд орсон этгээдэд ижил хандлага үзүүлэх, харин ялгаатай нөхцөл байдалд орсон этгээдэд бодит нөхцөлд нь нийцсэн, пропорциональ арга хэмжээ авах явдал юм. Цагдан хоригдсон хүний эдийн засгийн чадавхаас шууд хамаарахгүй албадлагын арга хэмжээний төрөл барьцаа авах, хувийн баталгаа гаргах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээнээс ялгаатай нь нөлөө бүх этгээдэд харьцангуй адил түвшинд мэдрэгдэх нөхцөл бүрддэг.

Мөн энэхүү албадлагын арга хэжээ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл

бүхий баримт, мэдээлэл байгаа урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоолыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх эрх зүйн зохицуулалттай тул бодит тэгш байдлыг хангах давуу талтай. Өөрөөр хэлбэл, ижил төрлийн гэмт хэрэгт шалгагдаж буй хүнтэй харьцуулахад ил тод үндэслэлээр албадлагын арга хэмжээг хэрэглэх боломжтой бөгөөд шийдвэр гаргагчийн дур зоргоороо хандах, субъектив үнэлгээнээс үүдэлтэй ялгаварлал үүсэх эрсдэл буурна. Энэ нь хууль хэрэглээний практикт тэгш байдлын зарчим бодитоор хэрэгжихэд чухал нөлөө үзүүлнэ.

Гэсэн хэдий ч, уг албадлагын арга хэмжээ авагдсан хүнийг ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх эрхэд нийцүүлэхэд эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн механизм онцгой ач холбогдолтой. Хэрэв цагдан хоригдох нөхцөл журмыг хуульд тодорхой, нэг мөр, ойлгомжтой тусгаагүй тохиолдолд тухайн таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан зарим бүлэгт илүү хүндээр, заримд нь харьцангуй хөнгөнөөр нөлөөлөх, эсхүл нийгмийн тодорхой бүлгийг бодитоор ялгаварлан гадуурхах эрсдэлтэй. Тиймээс хэрэгжилтийн явцад хяналт, гомдол гаргах, шүүхэд хандах баталгааг бүрэн хангах нь тэгш байх эрхийг хамгаалах чухал нөхцөл болно.

2. Оролцоог хангах

Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн эрхийг хангах боломжийг бүрдүүлсэн эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдалд өөрчлөлт гарахгүй. Харин зохицуулалтын хувилбар 2 нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх хуулийг шинэчлэн найруулах талаар тусгасан болно.

3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх хуулийг шинэчлэн найруулан батлуулснаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1 нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр зохицуулалт тусгахгүй. Энэ нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах боломжтой болох юм.

Харин зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах боломжтой гэж үзэж байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар дугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд “Хэнд ч эрүү

шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхийг хориглоно. Тухайлбал, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулж болохгүй.” гэж тус тус заасан хүний эрүү шүүлтээс ангид байх эрхийг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх заалт юм.

Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх тухайд, Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагын зохицуулалт нь тэр чигээрээ хариуцлагын механизмыг илтгэж байна. Зохицуулалтын хувилбар 2 нь энэхүү хүрээг нэмэгдүүлж байгаа тул хариуцлагын тогтолцоог дэмжинэ.

4. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх

Зохицуулалтын хувилбарууд нь хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байгаа бөгөөд цагдан хоригдогч өөрт болон бусдад гэм хор учруулж болзошгүй тохиолдолд таслан зогсооход чиглэгдэнэ.

5. Эрх агуулагч

Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1, зохицуулалтын хувилбар 2-ын тухайд эрх агуулагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд чиглэгдсэн зохицуулалтын нэмж тусгах шаардлагатай дурдсан.

6. Үүрэг хүлээгч

Энэ хэсэгт хүний эрхийг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээсэн этгээдийг тодорхойлсон эсэхийг авч үзнэ.

Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх тухайд, зохицуулалтын хувилбар 1, зохицуулалтын хувилбар 2-ын тухайд үүрэг хүлээгчийн эрх зүйн байдлын талаар асуудлыг тодорхойлсон болно. Өөрөөр хэлбэл, цагдан хоригдсон хүн болон алба хаагчийн эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлно.

7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх

Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх тухайд, улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д - Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын иргэн, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна” гэж заасан. Иймд зохицуулалтын хувилбарууд заавал тус хуульд нийцсэн байх ёстой.

Зохицуулалтын хувилбаруудад жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх нь шууд хамааралтай бөгөөд энэхүү үзүүлэлт нь хамгийн гол шалгуур үзүүлэлт болгоогүй хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлнэ.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний үнэлгээний зорилго нь тухайн зохицуулалтын хувилбар нь өсөлт, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадвар болон нийтийн баялагт хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тогтооход оршино. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг шууд болон шууд бус үр нөлөө гэж ангилагдана. Шууд үр нөлөөний энгийн жишээ бол зохицуулалтын хувилбарын улмаас улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсэх, аж ахуйн үйл ажиллагааны татварын хэмжээг өөрчлөх зэрэг байж болно.

Хүснэгт 5. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн	3.1.Зохицуулалтын хувилбарыг	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Хуулийн этгээдэд мэдээлэх үүрэг хүлээлгэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир улсын төсөвт нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зардлыг улсын төсвөөс шийдвэрлэнэ.

	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Холбогдох олон улсын гэрээний хэрэгжилт хангагдаж байгаа.

Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль нь эдийн засагтай шууд хамаарал багатай. Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь инновац болон судалгаа шинжилгээ, өмчлөх эрх, хэрэглэгч болон гэр бүлийн төсөв, дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна. Мөн мэдээлэх үүргийн улмаас хуулийн этгээдэд захиргааны зардлын ачаалал үүсэхгүй.

Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй учир эдийн засагт үзүүлэх үр нөлөө харьцангуй бага. Харин зохицуулалтын хувилбар 2 нь хууль батлан гаргах болон хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай зардлыг улсын төсвөөс шийдвэрлэх учир улсын төсвөөс зардал гарахгүй хувилбар 1-тэй харьцуулахад зардлын хувьд сөрөг үр нөлөөтэй гэж үзэж болох юм.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн болно. Нийгэмд үзүүлэх үр нөлөө нь үндсэн шинжийн хувьд олон хэлбэрийг агуулдаг бөгөөд өөр хоорондоо болон бусад төрлийн үр нөлөөтэй давхцах нь бий. Доорх хүснэгт 3-т нийгэмд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд дэлгэрэнгүй буюу нэмэлт тайлбарыг тухайлан бичсэн болно.

Хүснэгт 6. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Алба хаагчийн ажил сайжирна
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд нэмэлт өөрчлөлт орох
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Тодорхой нөлөө үзүүлнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд,	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт,	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

аюулгүй байдал	өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-г нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Хүний эрхийг дээшлүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 2	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	-	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Зохицуулалтын хувилбар 1 болон 2 аль аль нь соёл, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг болоод эерэг нөлөө үзүүлэхээргүй байна.

Гэхдээ цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагчид бол дараах хүний эрхийн асуудлууд хөндөгдөж байна. Тухайлбал,

Хөдөлмөр эрхлэлтийн талаар

Цагдан хоригдож буй хүний хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийг эрх зүйн болон хүний эрхийн үүднээс авч үзвэл, уг эрх нь бодит байдал дээр тодорхой хэмжээнд хязгаарлагдаж, зарим тохиолдолд хөндөгдөж байна гэж дүгнэж болно. Учир нь цагдан хорих арга хэмжээ нь тухайн этгээдийг нийгмээс тусгаарлах, тодорхой хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлах үндсэн шинжтэй боловч энэ нь бусад эрх, тухайлбал хөдөлмөрлөх эрхийг бүхэлд нь үгүйсгэх эрх зүйн үндэслэл болж болохгүй бөгөөд харин зайлшгүй шаардлагын хүрээнд, харьцангуй байдлаар зохицуулагдах ёстой. Гэвч одоогийн зохицуулалт болон практикт цагдан хоригдож буй этгээдэд хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөл, хэлбэрийг тодорхой тусгаж өгөөгүй, эсхүл бодитой хэрэгжих механизмаар хангаагүй байгаа нь энэ эрхийг бодитоор эдлэх боломжийг хязгаарлаж байна.

Түүнчлэн хөдөлмөрлөх эрхийг зөвхөн эдийн засгийн утгаар бус, хүний нэр төр, өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн оролцоог хадгалах чухал хэрэгсэл гэж үзэх шаардлагатай

атал цагдан хорих орчинд энэ чиглэлийн бодлого, зохицуулалт сул байгаа нь хүний эрхийн хамгаалалтын түвшнийг бууруулж байна.

Иймд цагдан хоригдож буй этгээдийн хөдөлмөрлөх эрхийг бүрэн үгүйсгэх бус, харин аюулгүй байдал, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулахгүй хүрээнд тодорхой нөхцөл, журмын дагуу хэрэгжүүлэх эрх зүйн боломжийг бий болгох шаардлагатай бөгөөд энэ чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь хүний эрхийг хангах, шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Учир нь ажил хөдөлмөр эрхлэх нь нийгэм, хөдөлмөрийн хамт олны дунд засарч хүмүүжих боломж олгох, нийгэмшүүлэх, дахин зөрчил үйлдэхээс сэргийлэх тухайд авч үзэх нь зүйтэй юм.

Сурч боловсрох эрхийн талаар

Цагдан хорих арга хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд зайлшгүй тохиолдолд хэрэглэгдэх ёстой боловч практикт хэрэгжихдээ хүний суурь эрхүүдийн нэг болох сурч боловсрох эрхэд бодитой саад учруулж байгааг эрх зүйн үүднээс дүгнэх боломжтой байдаг, учир нь цагдан хоригдсон этгээд нь гэм буруутай нь шүүхээр эцэслэн тогтоогдоогүй, өөрөөр хэлбэл гэм буруутгүйд тооцох зарчмын хүрээнд бүх суурь эрхээ хадгалж байх ёстой хэдий ч хорих орчны бодит нөхцөл, дотоод журам, нөөц бололцооны хязгаарлалт зэргээс шалтгаалан боловсрол эзэмших, сургалтад хамрагдах, өөрийгөө хөгжүүлэх боломж нь бодитоор хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл хоригдсон этгээдэд ном, сургалтын материал авах, зайнаас суралцах, шалгалтад оролцох, сургалтын байгууллагатай харилцах боломжийг хангах зохицуулалт тодорхой бус, эсхүл хэрэгжилт сул байгаа нь боловсролын эрхийг шууд бус байдлаар зөрчиж байгаа хэлбэр гэж үзэх үндэслэлтэй.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль нь шинэчлэн найруулан батлагдах эсэх асуудал нь байгаль орчинд шууд болон дам байдлаар сөрөг нөлөө бий болгохгүй. Үүнийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй авч үзлээ.

Хүснэгт 7. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 2	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Энэ хэсэгт зохицуулалтын 1 болон 2 дугаар хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэхийг шалгана.

Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль нь шинэчлэн найруулах зохицуулалтын хувилбар 2-ыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүнчлэн дотоодын бусад хуультай нийцэж байгаа эсэхийг дүгнэвэл, энэ хувилбар нь цагдан хоригдогчийн эрх зүйн байдлын талаар тодорхой нөхцөл, шалгуур, баталгааг хангасан тохиолдолд эрх зүйн хувьд нийцэх боломжтой, харин зохицуулалт тодорхой бус, хэт өргөн хүрээтэй байвал зөрчилдөх эрсдэлтэй гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хүний эрх, эрх чөлөөг үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор, хуулиар хязгаарлаж болохыг зөвшөөрсөн байдаг. Энэ утгаараа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хэргийн бодит үнэнийг тогтоох зорилготой, байдлаар хэрэгжүүлбэл Үндсэн хуулийн ерөнхий үзэл баримтлалтай зарчмын хувьд зөрчилдөхгүй гэж дүгнэж болно.

Олон улсын эрх зүйн хүрээнд авч үзвэл, Монгол Улс нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактаар төр, иргэний хуулийн өмнө тэгш байх, шударга шүүхээр шүүлгэх эрх, гэм буруугүйд тооцогдох эрх, үзэл бодол, ухамсар, шашин шүтэх эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван замаар жагсах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, төрийн алба хаших, сонгох, сонгогдох, мөн нийгмийн цөөнхийн эрхийг хамгаалах эрхүүдийг дурдаж болно. Аливаа улс хүнийг амь насыг дур зоргоороо хасахыг хориглох, эрүүдэн шүүх, хэрцгий, хүний нэр төрийг гутаан харьцах, шийтгэх, боолчлол, албадан хөдөлмөр, дур мэдэн баривчлах, цагдан хорих, хүний хувийн нууцад дур зоргоороо хөндлөнгөөс оролцох, дайны суртал ухуулга, ялгаварлан гадуурхах, арьс өнгө, шашны үзэн ядалтыг сурталчлах зэргийг хязгаарлах таслан зогсоохыг хуулиар хориглох талаар заасан.

Тус пактад хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй, хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй, баривчлагдсан болон эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй гэжээ.

Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно гэж заасан. Иймээс хувилбар 2 нь олон улсын гэрээтэй нийцэх эсэх нь түүний зохицуулалтын нарийвчлал, хэрэгжилтийн бодит байдлаас шууд хамаарна.

Эрүүдэн шүүх болон бусад хэрцгий, хүнлэг бус буюу нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенцод оролцогч улс орнууд эрүүдэн шүүх үйлдлээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, тайлагнах үүрэг хүлээдэг.

Конвенцод “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ (ХЭҮК, 2021, хууд. 540) гэж тодорхойлжээ.

Энэхүү конвенцын заалтын нийтлэг агуулга нь хоригдогчтой хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийг хориглох талаар заасан байдаг. Иймээс хувилбар 2 нь олон улсын гэрээтэй нийцэх эсэх нь түүний зохицуулалтын нарийвчлал, хэрэгжилтийн бодит байдлаас шууд хамаарна.

Монгол Улс 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр уг конвенцод гарын үсэг зурсан бөгөөд УИХ-аас 2014 оны 10 дугаар сарын 09-ний өдөр соёрхон баталсан. Хүчээр алба болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц нь товчхондоо дараах агуулгатайгаар хүний эрхийг хангаж байна (mfa.gov.mn, 2022).

- дайны болон бусад онц байдлын үед ч хэнийг ч үл тоомсорлож, албадан алга болгохыг хориглох;

- оролцогч улсуудад хүчээр алга болсон явдлыг эрүүгийн хариуцлага хүлээлгэж, шийтгэлтэй гэмт хэрэг тооцохыг үүрэг болгох;

- хүчээр алга болгох нь өргөн тархсан буюу системтэйгээр үйлдэгдсэн тохиолдолд хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болно гэдгийг батлах;

- сураггүй алга болсон хүмүүсийг эрэн сурвалжилж, сураггүй алга болсон эсэхийг шалгаж, хохирогчдод шударга ёс, нөхөн төлбөр авах боломжийг олгохыг улс орнуудад үүрэг болгох;

- хуульд зааснаар эрэн хайх, мөрдөн шалгах ажилд эрх зүйн туслалцаа үзүүлэх, хамтран ажиллахыг улс орнуудад үүрэг болгох;

- нууцаар саатуулах, цагдан хорихыг хориглох;

- эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн албан ёсны бүртгэлийг хамгийн бага мэдээллээр хөтөлж, тэдний гэр бүл, өмгөөлөгч болон өөрсдийн сонгосон бусад хүнтэй харилцах эрх олгох зэрэг эрх чөлөөг нь хасахтай холбоотой эрх зүйн наад захын стандартыг баталгаажуулахыг оролцогч улсуудад үүрэг болгосон байдаг. Иймээс хувилбар 2 нь олон улсын гэрээтэй нийцэх эсэх нь түүний зохицуулалтын нарийвчлал, хэрэгжилтийн бодит байдлаас шууд хамаарна.

Дотоодын бусад хуультай харьцуулбал, шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэр тухай хуульд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар хуульчилсан байдаг. Үүнд:

Шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу дараах үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авна.

Нэг. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан;

2. Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, эсхүл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

3. Хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

4. Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.

Хоёр. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид:

1. Гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан, гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан, хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн;

2. Эд хөрөнгө, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа насанд хүрээгүй хүний эсрэг, эсхүл амь нас, эрүүл мэнд, бусад шалтгааны улмаас өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

3. Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон;

4. Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

5. Монгол Улсад байнга оршин суудаггүй;

3. Яллагдагч өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эсхүл түүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болох үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол прокурорын гаргасан саналыг үндэслэн шүүх яллагдагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор;

4. Хорих ял эдэлж байгаа ялтныг яллагдагчаар татаж мөрдөн шалгах ажиллагаа явуулахад прокурорын саналыг үндэслэн шүүх түүнийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн цагдан хорих байранд шилжүүлнэ.

Яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар хүртэл байна. Шүүх цагдан хорих үндэслэл арилаагүй гэж үзвэл яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 6 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.

Харин Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг /хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/, 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг /хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар залилах/, 19.6 /хорлон сүйтгэх/, 29.5 /төрлөөр устгах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно.

Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно. Шүүгч баривчилсан, цагдан хорьсон цагийг захирамждаа заана.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, суллагдсан яллагдагчид урьд нь цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглоно.

Өсвөр насны яллагдагч, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй яллагдагч, жирэмсэн яллагдагчдыг урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

Шүүх яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргасан тохиолдолд:

1. Яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор яллагдагчийг цагдан хорьсон талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт, тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ;

2. Шүүхийн шийдвэрт тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт байрлах цагдан хорих байранд яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорихоор заана.

Шүүх дараах тохиолдолд прокурорын саналыг үндэслэн яллагдагч, шүүгдэгчийн цагдан хоригдох байрыг өөрчилж, өөр цагдан хорих байранд шилжүүлэхээр шийдвэрлэж болно:

а) авлигын гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг шалгах;

б) Эрүүгийн хуулийн 10.1 /хүнийг алах/, 19.4 /гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.7 /хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 20.7 /мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 29.9 /террор үйлдэхэд бэлтгэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэргийг шалгах;

в) яллагдагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол;

г) яллагдагчийн мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааг өөр нутаг дэвсгэрт явуулах бол.

Ерөнхийд нь дүгнэвэл, Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль нь шинэчлэн найруулах зохицуулалтын хувилбар 2 нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, дотоодын бусад хуультай зарчмын хувьд нийцэх бөгөөд хүний эрхийн талаар хуульд тодорхой тусгах, шүүхийн хяналт болон эрх зүйн баталгааг бүрэн хангах нөхцөлд л бодитой хэрэгжинэ. Эдгээр нөхцөлийг хангаагүй тохиолдолд уг зохицуулалт нь хүний эрхийн баталгаанд нийцээгүй зохицуулалт болж, Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилдөх эрсдэлтэй юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хувилбар 1. Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээх замаар асуудлыг шийдвэрлэх;

Хувилбар 2. Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэн найруулан батлуулах замаар цагдан хорих таслан сэргийлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх харилцааг боловсронгуй болгох.

Хүснэгт 8. Зохицуулалтын хувилбарыг харьцуулсан дүгнэлт

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1.	Хувилбар 2.
	Зорилгод хүрэх байдал	Эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад	Хууль эрх зүйн зохицуулалтыг цогц, уялдаатай байдлаар боловсронгуй болгох нь сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх, хүний эрх, эрх чөлөөний баталгааг бодитой, үр нөлөөтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болох бөгөөд цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн чанарыг дээшлүүлнэ.
	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тухайд өмнө зохицуулалт хэвээр үйлчилж байх тул тодорхой нөлөөлөл үзүүлэхгүй байна.	Эдийн засаг, нийгэмд үзүүлэх нөлөөний хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байсан бөгөөд хууль эрх зүйн орчныг сайжруулахад чиглэгдэж буй учир тодорхой зардал, цаг хугацаа шаардагдаж болзошгүй байна.
	Зардал, үр өгөөжийн харьцаа	Зардал нэмэгдэхгүй хэдий ч дээр дурдсан асуудлууд хэвээр оршсоор байна. Харин хуулийг шинэчлэн найруулан хэрэгжүүлснээр үр нөлөөг сайжруулах, илүү өндөр үр өгөөж бий болох боломжтой.	Хуулийг шинэчлэн найруулснаар хууль батлагдах үйл явцад шаардагдах зардлууд нь улсын төсвөөс гарахаар байна.
	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Одоогийн зохицуулалт хэвээр үргэлжлэх учраас одоо хэрэгжиж буй хууль тогтоомжтой зөрчилдөхгүй	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэн найруулж батлах замаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх харилцааг боловсронгуй болгох “хувилбар 2”-ыг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,

		Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн албаны тухай хуультай нийцэж байгаа эсэхийн үүднээс авч үзвэл, уг хувилбар нь тодорхой нөхцөл, шалгуур, эрх зүйн баталгааг хангаж чадсан тохиолдолд нийцэх боломжтой. Харин зохицуулалт нь тодорхойгүй, хэт ерөнхий эсвэл өргөн хүрээтэй байвал холбогдох хууль тогтоомжтой зөрчилдөх эрсдэлтэй гэж дүгнэж болно.
Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй сэжигтэн, яллагдагч. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч	Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан, шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй сэжигтэн, яллагдагч. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч, шүүх, прокурор, цагдаагийн алба хаагч

Гарч болох эерэг үр дүн

Эерэг үр дүнгийн хувьд хувилбар 1 нь өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1999 оны хууль бөгөөд хэрэгжилт, хяналтыг сайжруулах замаар хууль хэрэгжилтийн бодит байдлыг нэмэгдүүлэх давуу талтай. Энэ хувилбар нь шинэ төрлийн харилцааг бий болгохгүй тул хууль хэрэглээний тогтсон практикийг алдагдуулахгүй, байгууллагын чадавх, зохион байгуулалтын хүрээнд журам заавраар зарим харилцааг зохицуулах буюу богино хугацаанд

хэрэгжих боломжтой. Үүний үр дүнд хүний эрхийн зөрчил үүсэж болзошгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй байна.

Харин хувилбар 2 нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх харилцааг өргөжүүлж, хүний эрхийн зөрчлийг бууруулах, нарийвчлан зохицуулах, уян хатан болгох давуу талтай. Цагдан хоригдсон хүний эрх, үүрэг, хууль журмаар зохицуулсан харилцааг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой болох, хорих орчин нөхцөл, нөхцөл, тэгш бус байдлыг багасгах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг бодитоор хангах эерэг үр дүнтэй.

Гарч болох сөрөг үр дагавар

Сөрөг үр дүнгийн хувьд, хувилбар 1 нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй суурь асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хязгаарлагдмал байж болзошгүй. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулаагүй харилцааг журмаар зохицуулж байгаа нь хэрэгжилтийг сайжруулах оролдлого хийгдэж байгаа боловч хангалтгүй, хяналт сул хэвээр байгаа бөгөөд бодит үр нөлөө нь хүлээлтээс доогуур гарах эрсдэлтэй.

Нөгөө талаас, хувилбар 2 нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдан хоригдсон хүний эрх зүйн байдлыг илүү тодорхой зохицуулж, хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэгдэнэ. Харин (Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999)-ийг шинэчлэн найруулж хэрэгжүүлэхгүй тохиолдолд алба хаагчдын зүгээс дур зоргын шинжтэй шийдвэр гаргах, ижил нөхцөлд байгаа хүмүүст ялгавартай хандах, улмаар эрх тэгш байх зарчим зөрчигдөх эрсдэл үүсэх боломжтой. Түүнчлэн шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хяналт, зохион байгуулалтын шинэ механизм шаардлагатай тул төрийн зардал нэмэгдэх, эхний үе шатанд хэрэгжилтийн явцад ойлгомжгүй байдал үүсэх магадлалтай. Мөн эдийн засгийн хувьд уг хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад зохион байгуулалтын тодорхой зардал гарах боломжтой.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Дэлхийн улс орнуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цагдан хорих таслан сэргийлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт нь түүхэн хөгжлийн үе шатыг дамжин тасралтгүй боловсронгуй болж, хүний эрхийг дээдэлсэн чиг хандлага руу шилжсээр ирсэн байна. Улс орон бүрийн түүх, соёл, нийгмийн нөхцөл, эрх зүйн тогтолцооны онцлогоос хамааран хууль тогтоомжийн хөгжил, хэрэгжилт харилцан адилгүй боловч нийтлэг зорилго нь НҮБ-аас батлагдсан хүний эрхийн түгээмэл тунхаглалд нийцүүлэн хүний жам ёсны эрхийг хангах, хууль дээдлэх зарчмыг бэхжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэж байна.

Иймд эрх зүйн тогтолцоо ижил, төстэй болон хөрш улс орнуудын туршлагыг судалж, НҮБ-ын жишиг дүрэм, олон улсын гэрээ, конвенцын зохицуулалт, мөн зарим хөгжингүй орнуудын цагдан хорих шийдвэр гүйцэтгэх практик, эрх зүйн орчныг үндэсний тогтолцоотой харьцуулан шинжлэх зорилгоор дараах улс орнуудын цагдан хорих үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг товч авч үзэв.

6.1. Бүгд Найрамдах Хятад Ард Улсад цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй зарим онцлог

Тус улсын Дээд прокурорын байгууллагаас хууль бусаар урьдчилан хорихоос урьдчилан сэргийлэх чиглэлээр идэвхтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд цагдан хорих хугацааг үндэслэлгүйгээр сунгах явдал мэдэгдэхүйц буурч, цаашид ийм зөрчлийг гаргахгүй байх зорилгоор прокурорын болон олон нийтийн хяналтыг улам чангатган ажиллаж байна.

БНХАУ-ын “Цагдан хорих тухай журам”-д цагдан хоригдсон этгээдэд хүч хэрэглэх, бусад төрлийн гэмт үйлдэлд тооцогдох нөхцөл байдлыг долоон төрөлд ангилан тодорхойлж, тухайлбал хоригдлыг зодох, хүлэх, хууль бусаар зэвсэг хэрэглэх, хүчирхийлэл үйлдэх, бие махбодод гэмтэл учруулж хэрэг хүлээлгэх, амь насанд нь халдах, удаан хугацаагаар дааруулах, өлсгөх, хурц гэрлээр гялбуулах, түлэх, хайрах, мөн амиа хорлох, биеэ гэмтээхэд хүргэх зэрэг аливаа үйлдлийг хатуу хориглож, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.

Мөн Хятад улсын практикт сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих арга хэмжээг аль болох хязгаарлах, ялангуяа хүч хэрэглээгүй болон хөнгөн, хүндэвтэр гэмт хэргийн хувьд хорихоос зайлсхийж, барьцаа, батлан даалт зэрэг өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг түлхүү хэрэглэх хандлага ажиглагдаж байна.

НҮБ-аас тус улсын цагдан хорих ажиллагаанд хийсэн дүгнэлтдээ, цагдан хоригдож буй этгээд бүр өөрийн эрх зүйн байдлыг хараат бус, бие даасан шүүхээр хянуулах, шийдвэрийн үндэслэлийг шалгуулах боломжийг бүрэн хангах шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байна. Түүнчлэн зарим тохиолдолд захиргааны журмаар сэжигтэн, яллагдагчийг хорих, албадан сургалтад хамруулах зохицуулалт байгааг шүүмжилж, НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг тусгай илтгэгчээс ийм төрлийн арга хэмжээг хориглох, хүний эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой аливаа шийдвэрийг зөвхөн шүүх хуульд нийцүүлэн гаргах ёстойг зөвлөсөн байна.

Харин Монгол Улстай эрх зүйн тогтолцооны хувьд ижил төстэй шинжтэй ОХУ-ын зохицуулалтыг авч үзвэл, цагдан хорих ажиллагааг “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” болон түүнд нийцүүлэн баталсан “Баривчлах, цагдан хорих байрны дотоод журам”-аар зохицуулж байгаа бөгөөд эдгээрийг Монгол Улсын холбогдох хууль, журмуудтай харьцуулан судлах нь ач холбогдолтой юм.

6.2. ОХУ-ын Цагдан хорих төвийн үйл ажиллагааны дотоод дүрмээс

Нийтлэг үндэслэлийн хувьд, Эрүүгийн ял гүйцэтгэх тогтолцооны цагдан хорих төвийн үйл ажиллагааны дотоод дүрэм (цаашид дүрэм) нь Гэмт хэрэгт сэжиглэгдэж буй сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих тухай” хуулийн 16 дугаар зүйлд үндэслэн батлагдсан бөгөөд цагдан хорих төвийн үйл ажиллагааны дотоод журмыг зохицуулдаг. Энэхүү заалт нь уг дүрмийн эрх зүйн эх сурвалжийг тодорхойлохоос гадна зохицуулах харилцааны хүрээг тодруулсан чухал ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нийцүүлэн баталсан Баривчлах, цагдан хорих байрны дотоод журамтай агуулгын хувьд төстэй байна.

Мөн уг дүрэмд цагдан хорих төвд сэжигтэн, яллагдагчийн эрхийг хангах, тэдгээрийн үүргийг хэрэгжүүлэх, цагдан хорих нөхцөл, журмыг тодорхойлон зохицуулсан бөгөөд хоригдсон этгээд нь Холбооны хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлж, зан үйлийн тогтоосон дүрмийг мөрдөх үүрэгтэй. Үүргээ биелүүлээгүй, журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хариуцлагыг ногдуулах зохицуулалтыг мөн нарийвчлан тусгасан байна.

ОХУ-ын Цагдан хорих төвийн үйл ажиллагааны дотоод дүрмийн нэг онцлог нь сэжигтэн, яллагдагчид өөрийн нэрийн дансанд тулгуурлан авах боломжтой төлбөрт үйлчилгээний хүрээг харьцангуй өргөнөөр зохицуулсан явдал юм. Тухайлбал, дотоодын утсаар ярих, хувийн эмчийн үйлчилгээ авах, гаднаас хоол захиалах, үс засуулах зэрэг ахуйн болон үйлчилгээний боломжийг тодорхой хяналтын дор олгосон байдаг. Түүнчлэн сайн дурын үндсэн дээр хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлсэн нь мөн нэгэн онцлог зохицуулалт юм.

Харин Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид төлбөрт үйлчилгээний хүрээг хязгаарлагдмал байдлаар зохицуулсан байна. Тухайлбал, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 27 дугаар зүйл болон Баривчлах, цагдан хорих байрны дотоод журамд хоол хүнс, ахуйн хэрэглээ, хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн худалдаалах зэрэг цөөн төрлийн үйлчилгээг зөвшөөрсөн бөгөөд нэрийн дансны зохицуулалт, төлбөр тооцооны журмыг тодорхой заасан байдаг. Гэвч эдгээр үйлчилгээний төрөл, хүрээ нь өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлага болон цагдан хорих ажиллагааны бодит практикт бүрэн нийцэхгүй байгаа нь ажиглагдаж байна.

Иймээс хүний эрхийг бодитой хангах, цагдан хорих ажиллагааг олон улсын жишигт ойртуулах зорилгоор нэмэлт төлбөрт үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлага үүсэж байна. Тухайлбал, үс засах, гаднаас хоол авах, тодорхой техник хэрэгслийг түр хугацаагаар ашиглуулах, шаардлагатай бичиг баримтыг хуулбарлах зэрэг үйлчилгээг зохих хяналтын дор нэвтрүүлэх боломжтой. Харин эдгээрийг хэрэгжүүлэхдээ аюулгүй байдал, зохион байгуулалтын онцлогийг харгалзан бодит нөхцөлд нийцсэн журам боловсруулж, хууль тогтоомжид тусгах нь чухал юм.

Эдгээр зохицуулалтыг хуульд тусгаснаар сэжигтэн, яллагдагчийн мэдээлэл авах эрх, хувийн ариун цэврийг сахих нөхцөл сайжрах бөгөөд НҮБ-ын Хоригдогчидтой харьцах наад захын жишиг дүрэмд заасан шаардлагуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нөгөө талаар ОХУ-ын зохицуулалтад сэжигтэн, яллагдагчид тодорхой нөхцөл, хяналтын дор утсаар ярих боломж олгодог нь онцлог юм. Энэ нь мөрдөн шалгах байгууллага, шүүхийн зөвшөөрөлд үндэслэн, тусгай хяналттай орчинд, хугацаа болон агуулгын тодорхой хязгаарлалттайгаар хэрэгждэг. Харин Монгол Улсад сэжигтэн, яллагдагч нь захидал, цахилгаан зэрэг уламжлалт хэлбэрээр харилцах эрхтэй гэж хуульд заасан боловч энэ зохицуулалт нь орчин үеийн технологийн хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлагад төдийлөн нийцэхгүй болсон байна.

Өнөө үед цахим харилцаа, мэдээллийн технологийн хэрэглээ эрчимтэй өсөж, хүмүүсийн харилцааны үндсэн хэрэгсэл болсон хэдий ч хорих байгууллагын аюулгүй байдал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн явцыг хангах шаардлагаас үүдэн интернет болон гар утас ашиглах эрхийг хязгаарладаг. Гэвч энэ хязгаарлалт нь практикт тодорхой хүндрэл үүсгэж, ялангуяа гар утастай холбоотой зөрчил хоригдлуудын дунд нэлээд хувийг эзлэх болсон нь зохицуулалтыг шинэчлэх шаардлагатайг илтгэж байна.

6.3. Бүгд Найрамдах Казахстан Улсад цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй зарим онцлог

Казахстан Улсад урьдчилан хорих (цагдан хорих)-той холбоотой эрх зүйн зохицуулалт нь нэг хуульд төвлөрсөн бус, харин эрүүгийн процессын болон хорих нөхцөлийн гэсэн хоёр түвшний зохицуулалтаар хэрэгждэг онцлогтой. Үүнд:

1. 2014 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн №231 “Бүгд Найрамдах Казахстан Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд урьдчилан хорихыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хэрэглэх таслан сэргийлэх арга хэмжээний нэг хэлбэр гэж тодорхойлж, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэхээр зохицуулсан байна. Тус хуулийн 147, 148, 151 дүгээр зүйлүүдэд урьдчилан хорих арга хэмжээний эрх зүйн үндсийг тодорхойлон, тухайлбал 147 дугаар зүйлд шүүхийн зөвшөөрөлтэй хэрэглэх зарчмыг, 148 дугаар зүйлд хэрэгжүүлэх журам, 151 дүгээр зүйлд хугацаа болон сунгах механизмыг тус тус зохицуулжээ. Энэхүү зохицуулалтаас харахад урьдчилан хорих нь эрүүгийн шийтгэл бус, харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн явцыг хангах зорилготой албадлагын шинжтэй процессын арга хэмжээ болохыг тодорхой тусгасан байна.

2. 1999 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн №353-I “Хүмүүсийг нийгмээс түр хугацаагаар тусгаарлах зориулалт бүхий байгууллага, тусгай өрөөнд саатуулах журам, нөхцөлийн тухай” хуульд урьдчилан саатуулагдсан болон хоригдож буй этгээдийг байрлуулах, тэдгээрийн эрх, үүрэг, дотоод дэглэм, байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг нарийвчлан тогтоосон байна.

3. Урьдчилан хорих ажиллагааны өдөр тутмын хэрэгжилтийг зохицуулах зорилгоор Дотоод хэргийн сайдын 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн №95 тушаалаар мөрдөн шалгах дотоод журмыг баталж, хоригдсон этгээдийг хүлээн авах, байрлуулах, дотоод дэглэм сахиулах, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, уулзалт болон ахуйн зохицуулалтыг хэрэгжүүлэх нарийвчилсан журмыг тогтоосон байна.

Ийнхүү Казахстан Улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл урьдчилан хорих арга хэмжээний үндэслэл, журам нь эрүүгийн процессын хуулиар, харин түүнийг хэрэгжүүлэх нөхцөл, дэглэм, эрхийн баталгаа нь тусгай хууль болон дотоод журмаар зохицуулагддаг хоёр шатлалт тогтолцоотой байна. Энэ нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай ерөнхий бүтцийн хувьд төстэй бөгөөд аль аль улсад урьдчилан хорих арга хэмжээг процессын хуулиар тогтоож, хэрэгжилтийн нарийвчилсан журмыг тусгай хууль, дотоод актаар зохицуулж буй нийтлэг хандлага ажиглагдаж байна.

6.4. Япон Улсад цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй онцлог

Япон Улсад урьдчилан хорих (цагдан хорих) ажиллагааг хэрэгжүүлэх онцлог нь эрх зүйн зохицуулалтыг хоёр түвшинд тодорхой хуваарилан хэрэгжүүлдэг, мөн шүүхийн хатуу хяналт болон хүний эрхийн баталгааг өндөр түвшинд хангахад чиглэсэн байдлаар илэрдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд урьдчилан хорихыг зөвхөн хуульд заасан үндэслэл, шүүхийн захирамжийн дагуу хэрэглэхийг шаарддаг бөгөөд хорих, баривчлах, дуудах зэрэг аливаа албадлагын арга хэмжээг шүүхийн хяналтаас гадуур хэрэгжүүлэх боломжийг хаасан байна. Түүнчлэн хоригдсон этгээд өөрийн хоригдсон үндэслэлийг шүүхээр хянуулах, үндэслэлгүй болсон тохиолдолд хорих арга хэмжээг хүчингүй болгуулах эрхтэйгээрээ онцлогтой.

Харин урьдчилан хоригдсон этгээдийн байрлах нөхцөл, өдөр тутмын дэглэм, эрхийн баталгааг “Ял эдлүүлэх, саатуулах байгууллага болон хоригдол, саатуулагдагчтай харьцах тухай” хуулиар нарийвчлан зохицуулдаг бөгөөд энэ нь урьдчилан хоригдсон этгээдийг ял эдэлж буй этгээдээс ялгамжтайгаар авч үзэх, тэдний эрхийг хүндэтгэх зарчимд тулгуурладаг. Тухайлбал, оргож зугтах, нотлох баримт устгахаас сэргийлэх шаардлагыг хангахын зэрэгцээ өмгөөлөх эрх, уулзалт, захидал харилцаа, гомдол гаргах эрхийг бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Мөн хоригдсон этгээд гомдол гаргасны төлөө аливаа сөрөг хандлага, шахалтад өртөхөөс хамгаалагдсан эрх зүйн баталгаатай.

Үүнээс гадна өдөр тутмын дэглэмийг ил тод, тодорхой тогтоож, хоригдолд урьдчилан мэдэгдэх, өмгөөлөгчтэй саадгүй уулзах, тодорхой нөхцөлтэйгөөр ар гэрийнхэнтэй уулзах боломжийг олгодог нь хүний эрхийг бодитоор хангах практик механизм болж байна. Ар гэрийн уулзалтыг аюулгүй байдал, мөрдөн шалгах ажиллагааны шаардлагатай уялдуулан хязгаарлах боломжтой боловч тодорхой доод баталгааг хуулиар тогтоосон байдаг.

Ийнхүү Япон Улсад урьдчилан хорих ажиллагааг хэрэгжүүлэхдээ шүүхийн хяналтыг төвд тавьж, процессын болон гүйцэтгэлийн зохицуулалтыг ялган нарийвчилж, урьдчилан хоригдсон этгээдийн эрхийг хамгаалах, ял эдэлж буй этгээдээс ялгамжтай байдлыг хангах, өдөр тутмын дэглэм болон харилцааг ил тод, хүний эрхэд нийцтэй байдлаар зохион байгуулдаг нь гол онцлог юм.

6.5. Бүгд найрамдах Турк Улсад цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй зарим онцлог

Турк Улсад урьдчилан хорих буюу *tutuklama*-тай холбоотой харилцааг хэд хэдэн эрх зүйн актаар зохицуулдаг бөгөөд энэ нь процессын болон гүйцэтгэлийн зохицуулалтыг ялган хөгжүүлсэн тогтолцоотой юм.

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Criminal Procedure Code, Law No. 5271)-д урьдчилан хорих арга хэмжээний үндэслэл, шийдвэр гаргах журам, хугацаа, сунгалт

болон хорихоос өөр төрлийн хяналтын арга хэмжээг тусгасан байдаг. Тухайлбал, 100 дугаар зүйлд урьдчилан хорихыг хэрэглэхийн тулд гэмт хэрэг үйлдсэн гэх хүчтэй сэжиг, бодит нотлох баримт, мөн хорих зайлшгүй үндэслэл байхыг шаарддаг бөгөөд тухайн нөхцөлд хэт хатуу арга хэмжээ гэж үзвэл хэрэглэхээс татгалзах боломжийг нээж өгсөн. 101 дүгээр зүйлд хорих шийдвэрийг шүүхийн хяналтад, прокурорын хүсэлтэд үндэслэн гаргах журмыг тогтоосон бол 102 дугаар зүйлд хугацаа, сунгалтыг хязгаарлан, урьдчилан хорихыг хэт сунжруулахгүй байх баталгааг бүрдүүлжээ. Харин 109 дүгээр зүйлд урьдчилан хорихын оронд хэрэглэх *adli kontrol* буюу шүүхийн хяналтын арга хэмжээг зохицуулж, гадаад явахыг хориглох, тогтмол бүртгүүлэх, мөнгөн баталгаа гаргуулах, гэрийн хорио тогтоох зэрэг олон төрлийн зөөлөн хяналтын арга хэмжээг хэрэглэх боломжийг олгосон байна.

2. Ял, аюулгүй байдлын арга хэмжээг гүйцэтгэх тухай хууль (Law No. 5275) нь хорих байгууллагын дэглэм, хоригдогчтой харьцах зарчим, уулзалт, аюулгүй байдал, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоодог. Энэхүү хуульд ялгаварлан гадуурхахгүй байх, хүнлэг бус, доромжлон харьцахыг хориглох зэрэг хүний эрхийн суурь зарчмуудыг тусгасан нь онцлог юм.

3. “Ялтан болон хоригдогчийг эргэх, уулзуулах тухай журам” нь хоригдогчтой уулзах, эргэх ажиллагааны нөхцөл, хугацаа, хэлбэрийг нарийвчлан зохицуулдаг. Үүнд нээлттэй болон хаалттай уулзалтын хэлбэрийг ялган тогтоож, нээлттэй уулзалтыг тусгай зориулалтын орчинд, тодорхой цагийн хязгаар дотор зохион байгуулахаар заасан байна.

Турк Улсын зохицуулалтыг авч үзвэл урьдчилан хорих арга хэмжээг хэрэглэхдээ “хүчтэй сэжиг, бодит нотлох баримт, зайлшгүй шаардлага, пропорциональ байдал” гэсэн шалгуурыг чанд баримталдаг нь гол онцлог юм. Түүнчлэн *adli kontrol* зэрэг хорихоос өөр төрлийн хяналтын арга хэмжээг өргөн хүрээнд хөгжүүлсэн нь хүнийг заавал хорихоос зайлсхийж, эрх чөлөөг аль болох бага хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж байгааг илтгэнэ.

Монгол Улсын хувьд урьдчилан хорих арга хэмжээний үндэслэл, журам нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд, харин хэрэгжилтийн нөхцөл, дэглэм, эрхийн баталгаа нь тусгай хууль болон дотоод журмаар зохицуулагддаг нь Турк Улстай ерөнхий бүтцийн хувьд төстэй байна. Гэсэн хэдий ч Турк Улсын зохицуулалт нь урьдчилан хорих арга хэмжээг хэрэглэх пропорциональ шалгуур, мөн хорихоос өөр хувилбар арга хэмжээг илүү нарийвчлан хуульчилснаараа харьцангуй хөгжингүй, уян хатан тогтолцоотой гэж дүгнэж болно.

6.6. Бүгд найрамдах Франц Улсад цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлж буй зарим онцлог

Франц Улсад урьдчилан хорихтой холбоотой эрх зүйн зохицуулалт нь үндсэндээ хоёр түвшинд хэрэгждэг. Нэгдүгээрт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (*Code de procédure pénale*)-д урьдчилан хорих арга хэмжээний үндэслэл, хэрэглэх журам, шүүхийн хэлэлцүүлэг, хугацаа, сунгалт, суллах хүсэлт зэрэг процессын асуудлыг 143-1–148-8 дугаар зүйлүүдээр нарийвчлан зохицуулсан байдаг. Харин урьдчилан хоригдсон этгээдийн хорих байгууллага дахь нөхцөл, дотоод дэглэм, уулзалт, захидал харилцаа зэрэг гүйцэтгэлийн шинжтэй харилцааг Хорих байгууллагын тухай хууль (*Code pénitentiaire*)-аар зохицуулдаг.

Францын зохицуулалтын онцлог нь урьдчилан хорих арга хэмжээг хэрэглэхэд хатуу шалгуур тавьдагт оршино. Тухайлбал, 143-1 дүгээр зүйлд урьдчилан хорихыг зөвхөн

тодорхой төрлийн, харьцангуй хүнд хэрэгт хэрэглэхээр заасан бол 144 дүгээр зүйлд уг арга хэмжээг зөвхөн бодит баримтаар нотлогдсон нөхцөлд, мөн *contrôle judiciaire* буюу шүүхийн хяналтын арга хэмжээ, эсхүл цахим хяналттай гэрийн хорио зэрэг өөр арга хэмжээнүүд хангалтгүй үед хэрэглэнэ гэж тодорхойлсон байна. Энэ нь урьдчилан хорихыг “хамгийн сүүлчийн арга хэмжээ” болгон ашиглах зарчмыг илэрхийлдэг.

Мөн урьдчилан хорих шийдвэрийг эрх чөлөө, хорих асуудал хариуцсан тусгай шүүгч (*juge des libertés et de la détention*) гаргадаг бөгөөд тэрээр прокурорын санал, яллагдагч болон өмгөөлөгчийн тайлбарыг сонсож, мэтгэлцээний журмаар шийдвэрлэдэг. Ийнхүү хүний эрх чөлөөг хязгаарлах асуудлыг тусгайлан хариуцсан шүүхийн хяналтад шийдвэрлэдэг нь Францын тогтолцооны чухал онцлог юм.

Урьдчилан хорих хугацааны хувьд мөн тодорхой хязгаарлалтыг хуульчилсан байдаг. Хөнгөн ангиллын хэрэгт (*correctionnelle*) хугацаа нь богино, тодорхой дээд хязгаартай бол илүү хүнд (*criminal*) хэргийн хувьд тодорхой нөхцөлд илүү урт хугацаагаар үргэлжилж болох ч мөн хуульд заасан хязгаарын хүрээнд байна.

Харин хорих байгууллагын дотоод зохицуулалтын хүрээнд урьдчилан хоригдсон этгээдийн уулзалт, эргэлтийн асуудлыг *Code pénitentiaire*-аар нарийвчлан зохицуулдаг. Урьдчилан хоригдсон этгээд (*personnes prévenues*)-д олгох уулзалтын зөвшөөрөл нь тухайн хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл хүчинтэй байх бөгөөд ар гэр, ойр дотнын хүмүүс нь хорих байгууллагын тогтоосон хуваарь, журмын дагуу давтан уулзах боломжтой. Түүнчлэн долоо хоногт дор хаяж хэд хэдэн удаа уулзах боломжийг хангах чиг хандлага ажиглагддаг. Уулзалт нь зарчмын хувьд хаалтгүй орчинд явагдах боловч аюулгүй байдал, мөрдөн шалгах ажиллагааны шаардлагаас шалтгаалан тусгаарласан хэлбэрээр зохион байгуулах боломжтой.

Ийнхүү Франц Улсад урьдчилан хорих ажиллагааг хэрэгжүүлэхдээ шүүхийн тусгай хяналт, пропорциональ байдал, өөр арга хэмжээг нэн тэргүүнд хэрэглэх зарчим, мөн хоригдсон этгээдийн гэр бүлийн харилцааг хадгалах боломжийг дэмжсэн уян хатан зохицуулалтыг хослуулсан нь гол онцлог юм.

Монгол Улстай харьцуулахад хоёр улсын зохицуулалт ерөнхий бүтэц, зорилгын хувьд төстэй боловч уулзалтын зөвшөөрлийн тогтолцоонд ялгаа ажиглагдана. Францад нэг удаа олгосон уулзалтын зөвшөөрөл нь тухайн хэрэг шийдвэрлэгдэх хүртэл хүчинтэй байдаг бол Монгол Улсад уулзалт бүрд тусгайлан зөвшөөрөл авах шаардлагатай байдаг нь хяналтыг нарийвчлах давуу талтай ч практикт илүү ажиллагаа ихтэй зохицуулалт болж байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Тус судалгаа буюу (Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999) хуулийг шинэчлэн боловсруулах төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгааны хүрээнд 6 бүлэг бүхий аргачлалыг үндэслэн тандан судаллаа. Энэхүү үе шатуудыг дүгнэн үзвэл дараах үр дүнд хүрч байна.

Асуудлын гол шалтгаан нөхцөл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтны гаргасан захирамж, тогтоолыг үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй үндсэн зохицуулалт нь Улсын Их Хурлаас 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр баталсан “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль” юм. Гэвч нийгмийн харилцааны хөгжил, эрүүгийн процессын эрх зүйн шинэчлэлтэй уялдан хэрэгжүүлэх явцад тодорхой зохион байгуулалт, зохицуулалтын хүндрэлүүд үүсэх болсон. Тухайлбал, уг хууль нь 5 бүлэг, 45 зүйлтэйгээр анх батлагдсан 1999 оноос хойших хугацаанд 2000, 2002, 2003, 2013, 2017 онуудад болон 2020, 2024 онуудад нийт 10 удаа нэмэлт, өөрчлөлт орж, давхардсан тоогоор 47 зүйл заалтад өөрчлөлт хийгджээ. Гэвч эдгээр нэмэлт, өөрчлөлт нь нийгмийн харилцааны хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, цогц шинэчлэл хийх шаардлага байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хуулийн шинэчлэн найруулахтай холбоотой ба нийгэм, эрх зүйн шинэтгэлтэй зохицуулан сайжруулах шаардлагын талаар юм. Дээрх нөхцөл байдалтай холбоотой судалгааг өмнөх хэсгүүдэд оруулсан ба (Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал, 2016)-ын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг мөн тодорхойлсон.

Мөн үүнээс гадна тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэднээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан. Нэгдүгээр хувилбарын хувьд “Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай өнөөгийн эрх зүйн зохицуулалтыг хэвээр үлдээх замаар асуудлыг шийдвэрлэх” бол хоёрдугаар хувилбарыг “Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийг шинэчлэн найруулан батлуулах замаар цагдан хорих таслан сэргийлэх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх харилцааг боловсронгуй болгох” гэж тодорхойлсон.

Улмаар тус хоёр хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойлсон.

Эерэг үр дүнгийн хувьд хувилбар 1 нь өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1999 оны хууль бөгөөд хэрэгжилт, хяналтыг сайжруулах замаар хууль хэрэгжилтийн бодит байдлыг нэмэгдүүлэх давуу талтай. Энэ хувилбар нь шинэ төрлийн харилцааг бий болгохгүй тул хууль хэрэглээний тогтсон практикийг алдагдуулахгүй, байгууллагын чадавх, зохион байгуулалтын хүрээнд журам заавраар зарим харилцааг зохицуулах буюу богино хугацаанд хэрэгжих боломжтой. Үүний үр дүнд хүний эрхийн зөрчил үүсэж болзошгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл учирч болзошгүй байна.

Харин хувилбар 2 нь Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг гүйцэтгэх харилцааг өргөжүүлж, хүний эрхийн зөрчлийг бууруулах, нарийвчлан зохицуулах, уян хатан болгох давуу талтай. Цагдан хоригдсон хүний эрх, үүрэг, хууль журмаар зохицуулсан харилцааг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой болох, хорих орчин нөхцөл, нөхцөл, тэгш бус байдлыг багасгах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг бодитоор хангах эерэг үр дүнтэй.

Сөрөг үр дүнгийн хувьд, хувилбар 1 нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгарч буй суурь асуудлыг бүрэн шийдвэрлэхэд хязгаарлагдмал байж болзошгүй. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулаагүй харилцааг журмаар зохицуулж байгаа нь хэрэгжилтийг сайжруулах оролдлого хийгдэж байгаа боловч хангалтгүй, хяналт сул хэвээр байгаа бөгөөд бодит үр нөлөө нь хүлээлтээс доогуур гарах эрсдэлтэй.

Нөгөө талаас, хувилбар 2 нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд цагдан хоригдсон хүний эрх зүйн байдлыг илүү тодорхой зохицуулж, хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэгдэнэ. Харин (Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999)-ийг шинэчлэн найруулж хэрэгжүүлэхгүй тохиолдолд алба хаагчдын зүгээс дур зоргын шинжтэй шийдвэр гаргах, ижил нөхцөлд байгаа хүмүүст ялгавартай хандах, улмаар эрх тэгш байх зарчим зөрчигдөх эрсдэл үүсэх боломжтой. Түүнчлэн шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хяналт, зохион байгуулалтын шинэ механизм шаардлагатай тул төрийн зардал нэмэгдэх, эхний үе шатанд хэрэгжилтийн явцад ойлгомжгүй байдал үүсэх магадлалтай. Мөн эдийн засгийн хувьд уг хуулийг хэрэгжүүлэгч байгууллага болох шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад зохион байгуулалтын тодорхой зардал гарах боломжтой байна.

Харьцуулсан судалгааны хувьд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Франц Улсын эрх зүйн зохицуулалтууд болон Олон улсын гэрээний зохицуулалтыг тус тус судалсан.

Дэлхийн улс орнуудын цагдан хорих ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзвэл, улс бүрийн эрх зүйн тогтолцоо, шүүхийн бие даасан байдал, хүний эрхийн хамгааллын түвшин, болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх бодлогын онцлогоос хамааран өөр өөр хэлбэрээр хөгжсөн боловч нийтлэг чиг хандлагатай байна.

Судалсан улс оронд нийтлэг ажиглагдсан зүйл бол урьдчилан хорих ажиллагаа нь эрүүгийн шийтгэл бус, зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэвийн явцыг хангах зорилготой, онцгой нөхцөлд хэрэглэх албадлагын процессын арга хэмжээ болох нь нийтлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн байна. Мөн энэ арга хэмжээг хэрэглэх үндэслэл нь хангалттай сэжиг, бодит нотлох баримт, зайлшгүй шаардлага болон хамааралт байдлын шалгуурт тулгуурлах хандлага нийтлэг байна.

Мөн судлагдсан улс, орнуудын ихэнхэд цагдан хорих шийдвэрийг шүүхийн хяналтад, тусгай эрх бүхий шүүгч эсвэл шүүх бүрэлдэхүүн гаргах тогтолцоо давамгайлж байна. Франц, Япон зэрэг улсад хүний эрх чөлөөг хязгаарлах асуудлыг тусгайлан хариуцсан шүүгчээр шийдвэрлүүлдэг нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, эрх зүйн баталгааг нэмэгдүүлэх чухал алхам болж байна. Харин Турк, Казахстан зэрэг улсад мөн шүүхийн зөвшөөрөл, прокурорын хүсэлтэд тулгуурласан хяналтын тогтолцоо үйлчилж байна.

Цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн баталгаа, ялангуяа уулзалт, захидал харилцаа, өмгөөлөгчтэй харилцах эрх, гомдол гаргах эрх зэргийг улс орнууд харьцангуй нарийвчлан зохицуулж байна. Япон, Франц зэрэг улсад ар гэрийн уулзалт болон өмгөөлөх эрхийг илүү уян хатан, бодит боломжтой байдлаар хангаж байгаа бол зарим улсад Монгол Улсад зөвшөөрлийн давтамж өндөр, илүү хатуу хяналттай хэлбэр давамгайлж байна.

Цагдан хорих нөхцөл, дэглэм, журмын зохицуулалт нь хүний эрхийн олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр хөгжиж байна. НҮБ-ын наад захын стандарт дүрэм болон эрүүдэн шүүхээс сэргийлэх зарчмуудыг улс орнууд хууль тогтоомждоо тусгах хандлага нийтлэг байгаа бөгөөд хоригдсон этгээдтэй хүнлэг, ялгаварлан гадуурхахгүй харьцах зарчим бүх улсын эрх зүйн суурь болсон байна.

Судалгааны үр дүнг нэгтгэн үзвэл тандан судалгааны дүнгээр (Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, 1999) шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага нь харьцуулсан судалгаа болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуультай нийцүүлэн шинэчлэн найруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

НОМ ЗҮЙ

mfa.gov.mn. (2022 оны 09 17). mfa.gov.mn: <https://mfa.gov.mn/wp-content/uploads/>

Г.Совд. (1999). “Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх” /Харьцуулсан эрх зүй/. Улаанбаатар

Д.Цогтсайхан. (2012). “Хүний эрх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ”. Шүүх эрх мэдэл, 1:40-45.

МУЗГ. (2016). Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал. . legalinfo.mn, Нэгдүгээр хавсралт.

УИХ. (1992). Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэлгэл, №01.

УИХ. (1999). Сэжигтэн, яллагдагчийн баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль . Төрийн мэдээлэл эмхэтгэл, №34.

УИХ. (2016). Цэргийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №36.

УИХ. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №24.

УИХ. (2017). Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл , №23.

Хорих байрны дотоод журам, А/209 (ХЗДХ сайд 2017 оны 11 24).

Хүний эрхийн дээд комиссарын газар /Орч. Д.Зүмбэрэлхам/. (1994). Хүний эрх ба урьдчилан хорих ажиллагаа. Улаанбаатар.

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний зөвлөмжөөс, 06/29 (зөвлөмжөөс 2024 оны 12 25).

ХЭҮК. (2021). Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс. Улаанбаатар.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн журам, А/192 (ШШГЕГ-ын дарга 2017 оны 09 19).